



ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ТОГТОЛЦООНД НЭВТРҮҮЛЭХ НЬ: ХУВИРГАН ӨӨРЧЛӨХ БОЛОМЖУУД

Иргэний нийгмийн байр суурийн баримт бичиг

Улаанбаатар хот
2026 он

УИН.МН
СҮДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



**ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ
БОЛОВСРОЛЫН БОДЛОГО,
ТОГТОЛЦООНД НЭВТРҮҮЛЭХ НЬ:
ХУВИРГАН ӨӨРЧЛӨХ БОЛОМЖУУД**

Иргэний нийгмийн байр суурийн баримт бичиг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2026 он

Боловсруулсан

Ц.Баасаннямбуу ("Хөөрхөн зүрх" ТББ-ын кейс менежер)

Я.Мөнхчимэг ("Бүх нийт боловсролын төлөө!" Иргэний нийгмийн үндэсний эвслийн дэд зохицуулагч)

Б.Оюундарь ("Хөөрхөн зүрх" ТББ-ын ерөнхий зохицуулагч)

Х.Эгшиглэн ("Хөөрхөн зүрх" ТББ-ын сэтгэлзүйч)

Зөвлөх

Д.Тунгалаг ("Бүх нийт боловсролын төлөө!" Иргэний нийгмийн үндэсний эвслийн дэд зохицуулагч)

Зураг

артист @tarakash

Боловсролын төлөө чанга дуугарцаага төслийн санхүүжилтээр боловсруулан, хэвлэж түгээв.

EDUCATION **OUTLOUD**

advocacy & social accountability



ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ.....	4
ХУРААНГУЙ	5
НЭГ. ЖЕНДЭРИЙН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ БОЛОВСРОЛ.....	7
ХОЁР. БОЛОВСРОЛД ТУЛГАМДАЖ БУЙ ЖЕНДЭРИЙН СААД БЭРХШЭЭЛҮҮД: МОНГОЛ УЛСАД.....	11
ГУРАВ. БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ КОНВЕНЦ, ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД	17
ДӨРӨВ. ЖЕНДЭРИЙН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ БОЛОВСРОЛ.....	23
4.1 БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ЖЕНДЭРИЙГ НЭГТГЭСЭН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ	24
4.2 ЖЕНДЭРИЙН ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛДЭГ СУРАЛЦАХУЙН ОРЧИНД ТАВИГДДАГ МИНИМАЛ СТАНДАРТ.....	25
4.3 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, СУРАХ БИЧИГ, СУРГАЛТЫН МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ ЗАРЧИМ.....	26
4.4 БАГШЛАХУЙ БА ЖЕНДЭРИЙН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ	28
4.5 СУРГУУЛИЙН ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ	32
4.6 ЖЕНДЭРИЙН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ БОЛОВСРОЛЫН ТӨСӨВ.....	34
4.7 ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛ.....	37
4.8 БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ЖЕНДЭРИЙН ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛДЭГ БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ	38
4.9 САЛБАР ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	41
БИДНИЙ ХУВИРГАН ӨӨРЧЛӨХ СТРАТЕГИ.....	45
ТУНХАГ	48

ТОВЧИЛСОН ҮГ

БНҮЭ	Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖҮХ	Жендэрийн Үндэсний Хороо
ЖХТ	Жендэрийн хариуцлагатай төсөвлөлт
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МБСТ	Мэргэжлийн боловсрол, сургалтын төв
МБШУҮЭХ	Монголын Боловсрол, Шинжлэх ухааны Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо
МҮАХ	Марракешийн үйл ажиллагааны хүрээ
МХТ	Мэдээлэл, харилцаа холбоо
НХБ	Насанд хүрэгчдийн боловсрол
НТБ	Насан туршийн боловсрол
НТС	Насан туршдаа суралцахуй
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ШУТИМ	Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ХШҮ	Хяналт шинжилгээ-үнэлгээ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХУРААНГУЙ

Боловсрол хувирган өөрчлөгч хүчтэй. Жендэрийн тэгш байдал ба жендэрийн тэгш эрхийг хангахын төлөө боловсролын салбарын энэ чадамжийг бид бүрэн дүүрэн дайчлахгүй байна. Сүүлийн 20 гаруй жилд бид боловсролд жендэрийн тэнцвэрт байдлыг дэлхий даяар үлэмж ахиулж чадсан. Гэвч энэ бол зөвхөн хүртээмж болон элсэлтийн тэгш байдлыг харуулж байгаа юм. Тиймээс бид хүрээмжээс цааш ахиж, жендэрийн тэгш бус байдлыг гүнзгийрүүлэн бэхжүүлж байгаа боловсролын тогтолцооны эд эс бүрийг; тухайлбал багш, сургалтын хөтөлбөр, арга зүй, агуулга зэргийг өөрчлөх шинэ зорилгыг тавьж байна. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх, жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоог нэмэх, нийгмийн бүлгүүд хөгжлийн үр шимийг эрх тэгш хүртэх байдлыг баталгаажуулах өөрчлөлтийн суурийг боловсролын орон зайд соёолуулахаар “жендэрийн хувирган өөрчлөх боловсрол”-ын үзэл баримтлал, хандлага арга зүйг сонгож байна. Бидний хэдийн мэдэх “жендэрийн мэдрэмжтэй” боловсролын хандлага нь жендэрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөөд л орхидог, “жендэрийн хариу үйлдэл үзүүлэгч” хандлага нь жендэрийн тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авдгаараа нэг алхам урагшилсан ч нийгэмдээ тааруулан ажиллаж “шинж тэмдгийг л эмчлэхэд” чиглэдэг. Бидний сонгож буй “жендэрийн хувирган өөрчлөх” хандлага, арга зүй жендэрийн тэгш бус байдлын суурь шалтгаан болох жендэрийн хэм хэмжээг өөрчлөх, эрх мэдлийн тэгш бус харилцааг нураах замаар ялгаатай хэрэгцээтэй хүүхэд нэг бүрт боломж олгох боловсролын тогтолцоо болгон үндсээр нь хувирган өөрчилнө. Эцсийн зорилго нь эмэгтэй, эрэгтэй, охид, хөвгүүд болон бэлгийн цөөнх хүмүүс нийгэмд ашиг тустай бараа үйлчилгээ (боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц гэх мэт), боломж, нөөц, урамшууллыг тэгш хүртэх буюу эрхийг нь тэгш хангахад оршино.

Жендэрийн хувирган өөрчлөх боловсролыг бодитой хэрэгжүүлэхийн тулд энэ үзэл баримтлалын талаар оролцогч талууд мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэх, зөвхөн жендэрийн асуудлыг салгаж үзэлгүй огтлолцлын хандлага-арга зүйг ашиглах, орон нутагт нийгэм-соёлын нөхцөлд нийцсэн бодлого, үйл ажиллагааг төлөвлөх хэрэгтэй болдог. Тогтвортой үр дүнд хүрэхэд эсвэл боломжит байдлаар нөлөөлөхөд сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт, багшийн боловсрол, дэмжлэг, удирдлагын менежмент, олон нийтийн оролцоо түлхэц болох эсвэл хойш чангаа хүчин зүйл болно. Жендэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад байгууллагын болон хувь хүний чадавхын хязгаарлагдмал байдал, мөн нийгэм, улс төр-эдийн засгийн асуудлууд болон бусад нөхцөл байдлын хүчин зүйлс нөлөөтэй.

Зураг 1. Жендэрийн хувирган өөрчлөх хандлага арга зүй гэж юу вэ?

Жендэрт суурилан мөлжсөн (Gender Exploitative)	Жендэрийн харалган (Gender-blind)	Жендэрийн мэдрэмжтэй (Gender-sensitive)	Жендэрийн хариу үйлдэл үзүүлдэг (Gender-responsive)	Жендэрийн хувирган өөрчлөх (Gender-transformative)
Тэгш шударга бус нийгмийн хэм хэмжээ, дүр, харилцааг санаатай болон санамсаргүй бэхжүүлэн жендэрийн тэгш бус байдлыг нэмэгдүүлдэг.	Жендэрийн хэм хэмжээ, хэвшмэл ойлголт, дүр-үүрэг, харилцааг үл хайхрах ба энэ нь голдуу жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтыг бэхжүүлдэг.	Жендэрийн хэм хэмжээ, хэвшмэл ойлголт, дүр-үүрэг харилцааг анхаарч тооцдог ч тэгш бус байдлыг бууруулахыг зорьдоггүй.	Жендэрийн хэм хэмжээ, хэвшмэл ойлголт, дүр-үүрэг, харилцааг харгалзан, тэгш бус байдлыг бууруулахыг зорьдог.	Жендэрийн хэм хэмжээ, дүр, харилцааг сөрж, суурь шалтгааныг харгалзан, тэдгээрийг хувирган өөрчлөхийг зорьдог.
Үл ойшоох, зайлсхийх		Аргацаах		Хувирган өөрчлөх

Амжилтанд хүрэхийн тулд бодлого гаргахаас хэрэгжилт хүртэлх цогц арга хандлага шаардлагатай. Жендэрийн хувирган өөрчлөх боловсрол гэдэг нь бодлого, үйл ажиллагааг жендэрийн линзээр харж, сургалтын хөтөлбөрийг суралцагчдын ялгаатай байдлыг харгалзан боловсруулж, хичээл нэг бүрийн үйл явц тэгш хамарсан байхыг шаарддаг. Мөн багш нарт суралцагчдынхаа ялгаатай хэрэгцээг ойлгож, түүнд нийцсэн боловсрол олгох ур чадвар суулгах, суралцагчдад мэдрэмжээ (санаа зовнил) илэрхийлэх аюулгүй ээлтэй орчин бүрдүүлэхээс эхэлнэ. Үүний зэрэгцээ сургуулийн төсөв нь жендэрийн хариуцлагатай байхаас гадна удирдах болон багшлах талбарт эмэгтэй, эрэгтэйчүүдэд ижил тэгш орон зай, боломж олгох төдийгүй боловсролын тогтолцоонд оролцогч бүх талтай хамтран ажиллаж, жендэрийн тэгш байдал, тэгш эрхийг хангахад тулгарч байгаа бүх саад тотгорыг илрүүлэн гаргаж, цогцоор шийдвэрлэх гэсэн үг юм.



НЭГ. ЖЕНДЭРИЙН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ БОЛОВСРОЛ

Жендэрийн хувирган өөрчлөлт хийх боловсролын гол зарчим нь боловсролыг бүх хүний эдлэх үндсэн эрх хэмээн үе хоорондын болон эрхэд суурилсан хүрээнд хэрэгждэг гэж үздэг. Жинхэнэ утгаараа хувирган өөрчлөхийн тулд хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн боловсрол, насан туршийн суралцахуйг бүхэлд нь багтаах шаардлагатай. Суралцагчдын боловсрол эзэмшихэд тулгарч буй жендэрийн саадыг арилгах, тэднийг чадавхаа бүрэн ашиглахад тээг болж буй аливаа хэм хэмжээг өөрчлөх ёстой. Боловсролын салбарт болон боловсролоор дамжуулан жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь “Боловсролыг хувирган өөрчлөх” санаачилгын гол цөм бөгөөд 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх арга зам. НҮБ боловсрол эзэмших хийгээд насан туршийн суралцахуйн эрх нь хэнийг ч орхигдуулахгүйгээр ТХЗ-уудад хүрэх тулгуур зарчим хэмээн чухалчилдаг. Гэсэн ч тэгш бус байдал оршсон хэвээр төдийгүй эмзэг буюу маргиналчлагдсан бүлэг, охид, эмэгтэйчүүд, нийгэм-эдийн засгийн статус доогуур хөвгүүд, бэлгийн болон хүйсийн цөөнхийг орхисоор, бага орлоготой, хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, алслагдсан газар амьдардаг, шилжин суурьшсан иргэд боловсролоос гадуурхагдсаар байна. Жендэрийн хувирган өөрчлөх боловсролын хандлага-арга зүй нь эрх тэгш байдлыг хангахыг ухамсартайгаар зорьж, хэнийг ч орхигдуулахгүйн тулд бодлого, төлөвлөгөөг боловсруулах, шаардагдах төсөв хөрөнгө хуваарилах арга хэлбэрийг тогтолцоогоор нь өөрчлөхийг асуудлын шийдэл гэж хардаг.

Жендэрийн хувирган өөрчлөх боловсролын хандлага-арга зүйг ашиглан, ТХЗ 4-т тодорхойлсон НҮБ-ын “Бидний нийтлэг зорилго: Хувирган өөрчлөх боловсрол”²-д дурдсан бүх нийтэд зориулсан тэгш хамруулах, тэгш хүртээмжит боловсрол, насан туршийн суралцахуйг санал болгож байна. Энэхүү хандлага, шаардлагыг Зураг 1-т тодруулж, дэлгэрэнгүй тайлбарласан болно.

2022 онд³ НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеришийн ивээл дор зохион байгуулагдсан “Хувирган өөрчлөх боловсрол” дээд хэмжээний уулзалтыг угтан Монгол улсын БШУЯ, НҮБ-ын Монгол дахь суурин зохицуулагчийн газар, НҮБ-ын Хүүхдийн Сан, болон НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын (ЮНЕСКО) дэмжлэгтэйгээр үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг үе шаттайгаар олон талын оролцоог ханган зохион байгуулсан. Энэхүү олон талт хэлэлцүүлэгт хүүхэд, залуучууд, багш, судлаачид, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид, хэвлэл мэдээллийн болон төрийн байгууллагын

1 Gender transformative education – Боловсролын тогтолцооны бүх хэсгийг (бодлого, сургалтын агуулга, арга зүй, олон нийтийн оролцоо зэрэг) ашиглан жендэрийн талаарх хэвшмэл ойлголт, хандлага, хэм хэмжээ практикийг өөрчлөхөд чиглэдэг. <https://www.unicef.org/media/113166/file/GenderTransformativeEducation.pdf>

2 “Бидний нийтлэг зорилго” бодлогын хураангуй, Хувирган өөрчлөх боловсрол, НҮБ 2023 он <https://www.un.org/sites/un2.un.org/files/our-common-agenda-policy-brief-transforming-education-en.pdf>

3 “Хувьсаж буй боловсрол” Монгол Улсын санаачилга, 2022 он

төлөөлөл оролцож, боловсролын салбарт, буй асуудал, ялангуяа ковид-19 цар тахлаас үүдэлтэй боловсрол, сургалтын хоцрогдол, алдагдсан боломжийн талаар хэлэлцэж, ирээдүйн боловсролын дүр төрх, алсын хараа, амлалтыг тунхаглан “Монгол Улсын Тэргүүлэх Санаачилга”-ыг батлан, НҮБ-ын “Хувирган өөрчлөх боловсрол” дээд хэмжээний уулзалтын үеэр амлалт авсан билээ.

Зураг 2. ТХЗ-ын төлөөх Жендэрийн хувирган өөрчлөх боловсрол⁴



Сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багш нар, сургуулийн удирдлагад жендэрийн өрөөсгөл хандлага байсаар байгаа нь боловсролын чанарт сөргөөр нөлөөлдөгийг судлаачид тогтоожээ. Жендэрийн хувирган өөрчлөх боловсрол нь хүүхдийн төлөвшилд эерэг нөлөөтэй бөгөөд хүүхдүүдэд хүндэтгэл, тэгш байдлын чухал үнэт зүйлсийг сургаж, хүлцэн тэвчдэг, хүчирхийлэл үйлддэггүй насанд хүрэгчид болон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлдэг. Мөн шүүмжлэлт сэтгэлгэй, эрх тэгш, хүлээцтэй хандлагыг төлөвшүүлж, нээлттэй ярих, хэлэлцэх ур чадварыг хөгжүүлэх замаар нийгэмд аливаа хэлбэрийн зөрчлийг бууруулах боломжтой. Жендэрийн хувирган өөрчлөх боловсрол нь жендэрийн хэм хэмжээг эвдэж, «хэвшмэл ойлголтыг арилгах» замаар нийгэм дэх ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлыг үгүй болгох арга юм.

2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг ЖҮХ-ноос хийхэд соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах 7 заалтын 3 заалтад ахиц дэвшил

4 Ази-Номхон далайн бүс нутаг дахь Жендэрийн хувирган өөрчлөх боловсролын төлөөх бүсийн тунхаглал, 2025 он

гарсан хэдий ч 4 заалтын хувьд ахиц төдийлөн гараагүй буюу “дунд” түвшинд үнэлэгджээ. Боловсрол, шинжлэх ухааны салбарын жендэрийн бодлого стратеги (2017-2024 он) батлагдан хэрэгжсэн ч 2022 оныг багтаан дунд хугацааны хэрэгжилтийг ЖҮХ-ноос үнэлж үзэхэд нийт 13 хүрэх үр дүн, үйл ажиллагааны үндсэн чиглэлээс 2 нь амжилттай хэрэгжсэн, 9 нь харьцангуй амжилттай, 2 нь амжилтгүй хэрэгжиж байна гэж үнэлэгдэв. Тодруулбал, стратегид тусгасан 42 үйл ажиллагааны 2 нь маш амжилттай, 12 нь амжилттай, 15 нь харьцангуй амжилт гаргаж эхэлсэн, харин 13 үйл ажиллагаа огт хийгдээгүй орхигдсон байв. Эдгээр бодлого, төлөвлөгөөнүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь иргэдийн, тухайлбал хүүхэд залуучуудын өдөр тутмын амьдрал төдийгүй ирээдүйн хувь заяанд нь нөлөөлдөг гэдгийг дараах хэсгээс харж болно.





ХОЁР. БОЛОВСРОЛД ТУЛГАМДАЖ БУЙ ЖЕНДЭРИЙН СААД БЭРХШЭЭЛҮҮД: МОНГОЛ УЛСАД

1. Монгол улс нь эмэгтэйчүүд дунджаар эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсрол эзэмшсэн байдаг ба боловсролын хувьд жендэрийн урвуу хамааралтай орон юм. Тухайлбал, 2022 онд насанд хүрсэн эмэгтэйчүүдийн 36 хувь дээд боловсрол дүүргэсэн байсан бол эрэгтэйчүүд 27 хувь дээд боловсролтой байсан⁵. Дээд боловсролын зөрүү сүүлийн жилүүдэд буурч байгаа ч өсөлт ихэнхдээ хот суурин газраар хязгаарлагдаж байна. Боловсрол дахь жендэрийн зөрүүгийн урвуу хамаарал нь хөвгүүдийн цөөнх нь ахлах сургууль руу, улмаар дээд боловсрол руу шилжиж байгаагаар тайлбарлаж болно.
2. Нийт хүн амын 28-30 хувь ядуу байна. Ядуу таван хүн тутмын хоёр нь 15-аас доош насны хүүхэд.⁶ 2022 оноос эхлэн төрөөс авсан зорилтот арга хэмжээнүүдийн үр дүнд СӨБ-д хамрагдалтын хувь хэмжээ нэмэгдэж байгаа ч амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой эцэг эхтэй хүүхэд хамрагдаж чадахгүй байна⁷.
3. Их дээд сургуульд элсэн орж, мэргэжил эзэмшиж буй эрэгтэй, эмэгтэй оюутнуудын дунд мэргэжлийн талбарын хувьд ялгаа их. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол эрүүл мэнд, боловсрол, нийгмийн ажилд мэргэших нь 26 хувиар илүү байхад эрэгтэй оюутнууд инженерчлэл, МХТ зэрэг ШИМТ-ийн салбарын мэргэжил эзэмших магадлал 26 оноогоор өндөр⁸. Монгол улсад суралцах мэргэжлийн чиглэлийн хувьд хүйсийн тэнцвэргүй байдал байгаа нь шинжлэх ухааны аль салбар эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс илүү тохирохыг зааварчилж тулгадаг нийгэмд гүн тогтсон хэм хэмжээнээс үүдэлтэй байх магадлалтай. Эмэгтэй оюутнууд эрэгтэй оюутнуудтай харьцуулахад ШИМТ-ийн салбараас мэргэжлээ сонгох магадлал 80 хувиар бага⁹ охид математик, шинжлэх ухааны хичээлүүдийн стандарт үнэлгээгээр илүү өндөр оноо авдаг ч судлагдахууны хувьд өөрсдийн мэдлэг, чадварт итгэх итгэл доогуур байна. Энэ нь багш нарын сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөх нөлөө давамгайл, багш нарын заах арга зүй, хандлага, жендэрийн хэвшмэл ойлголт хүүхдүүдийн мэргэжил сонголтод тодорхой нөлөөтэй байгаагаас үүдэлтэй¹⁰.

5 Монгол улс: Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ (2024 оны 6-р сар), Дэлхийн банк, Х-43

6 "Ядуурлын дүр төрх" судалгааны тайлан, УСХ, 2018 он

7 Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Хүний эрхийн Үндэсний Комисс, 2024 он

8 Монгол улс: Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ (2024 оны 6-р сар), Дэлхийн банк, х-45

9 ТХЗ 4-ийн дунд хугацааны хэрэгжилтийн тайлан, БШУЯ, 2022 он

10 Сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөх

4. Монгол улсад эмэгтэйчүүдийн боловсролын давуу тал нь сургууль төгссөний дараа болон хөдөлмөрийн зах зээлд орох үед бодит өгөөжөө өгдөггүй¹¹. Энэ нь гэр бүлдээ асран халамжлах үүргийг тэнцвэргүй үүрч байгаагаас ажиллах хүчинд оролцоход боловсролоос хамааралгүй саадуудыг бий болгодог. 2022 оны цаг ашиглалтын судалгаагаар, өдөрт дунджаар 3,5 цагийг гэрийн ажил, хөлсгүй асаргааны ажилд зарцуулсан нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2 дахин их байсан¹². Ажил эрхэлдэг хүн амын дунд ч эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 72 хувийн илүү цагийг гэр орны үүрэг хариуцлагад зарцуулдаг нь ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн хувьд давхар ачаалал болдог бөгөөд мэргэжлийн хөгжилдөө анхаарах, орлогоо нэмэгдүүлэх, албан тушаал ахиж дэвших зэрэг боломжуудыг хойш татдаг.
5. Жендэрийн хортой хэм хэмжээ хөвгүүдийн боловсрол эзэмшихэд сөргөөр нөлөөлж байгаад бодлогын анхаарлыг хандуулах шаардлагатай. Сургуулийн гадна байгаа хүүхдийн 62,3 хувь нь хөвгүүд. Үүний дийлэнх хувийг малчин өрхийн хөвгүүд эзэлдэг. PISA¹³ олон улсын сурлагын амжилтын үнэлгээний дүнгээр, хөвгүүдийн сурлагын амжилт охидоос доогуур. Ялангуяа шинжлэх ухаан, унших чадварт зөрүү ихтэй. Хөвгүүд дээд боловсролд хамрагдах түвшин, тэдний сургуульд суралцах хүлээлт, дундаж хугацаа буурсан. Эцэг эх, багш нарын жендэрийн хэвшмэл ойлголт, хандлага охид хөвгүүдэд ялгаатай хүлээлтийг бий болгож, хөвгүүдийг илүүтэй үл хайхарч, хүмүүжлийн эерэг аргаар харилцахгүй байгаа нь хортой эрэгтэйлэг чанарыг бий болгож байна¹⁴.
6. Монголын сургуулиуд бол ЛГБТИК сурагчдад, тухайлбал транс сурагчдад ээлтэй, аюулгүй орчин биш. Хүйсээр ангилан хуваах соёл боловсролын тогтолцооны бүрдэл хэсэг бүрт гүн бат оршиж, тэр нь трансжендер¹⁵ олон нийт хүмүүсийн талаарх буруу ойлголт, хайхрамжгүй, харалган тоомжиргүй байдлыг өөгшүүлж буйг, түүнчлэн транс сурагчдын эсрэг үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл, багш нарын сөрөг хандлага нийтлэг байсаар байгааг онцолж байна. Судалгаанд оролцогчдын олонх нь багш, гэр бүл, үе тэнгийнхэн, үл таних хүмүүсийн зүгээс үг хэл, бие махбодын хүчирхийлэл, тэр бүү хэл бэлгийн дарамт амсаж байгаа нь тэдний сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээ авах боломжгүй, ялгаварлан гадуурхалт, таагүй үйл явдлууд тохиолдох, түүнчлэн багш, сургуулийн сэтгэлзүйчид үл итгэх зэргээс дээр дурдсан эрсдэлд өртөмтгий байснаар дийлэнх транс сурагчид тусламж дэмжлэг эрэлхийлэхээс зайлсхийдэг¹⁶.

байдал" судалгааны тайлан, "Хөөрхөн Зүрх" ТББ, 2024 он

- 11 Ази-Номхон далайн бүс нутаг дахь Жендэрийн хувирган өөрчлөх боловсролын төлөөх бүсийн тунхаглал, <https://www.ungei.org/sites/default/files/2025-03/FemNet4GTE%20Regional%20Declarations%202024%20ASIA%20%26%20PACIFIC.pdf>
- 12 Монгол улс: Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ, 2024, Дэлхийн банк, х-55
- 13 PISA 2022 (OECD)
- 14 "Боловсролоос хөндийрч буй хөвгүүд" судалгааны тайлангаас, 2024 он
- 15 Трансжендер- Төрөх үед тэмдэглэсэн хүйстэй холбоотой давамгайлалч соёл, нийгмийн хүлээлтээс өөр хүйсийн баримжаа, илэрхийлэлтэй хүмүүсийг нэрлэдэг толгой нэр томьёо.
- 16 "Монголын сургуульд транс сурагч байх нь" кейс судалгааны тайлангаас, Боловсрол эвсэл & ЛГБТ төв, 2023 он

7. Хурдан морь унаач хүүхдүүд уралдааны үеүдэд дор хаяж 30 хоног сургуулиас завсарддаг. Монгол Улсын хэмжээнд хурдан морь унаач 15.885 хүүхэд бүртгэлтэй байгаагаас 15.403 эрэгтэй, 482 эмэгтэй хүүхэд байна. Энэ нь нийт хурдан морь унаач хүүхдийн 96 хувь нь эрэгтэй, 4 хувь нь эмэгтэй хүүхэд эзэлж байгааг илтгэдэг, 14.082 хүүхэд орон нутгийн, 1,797 хүүхэд Улаанбаатар хотын харьяалалтай байна¹⁷. Хурдан морь унаач хүүхдүүд хичээлээс чөлөө авах, таслах байдал, эсхүл хичээлдээ явсан ч гэрийн даалгавараа хийхгүй байх нь их байдаг тул хоцорсон хичээлийг нөхөж заах, хоцрогдлыг арилгах арга хэмжээ авах нөхцөл боломж хомс. Хурдан морь унаж уралдах шалтгаанаар хичээлээс хоцрогдсоны улмаас сурах сонирхол идэвхгүй болсон хүүхдүүд тухайн уяач, эздийнхээ морь малын бусад ажлыг хийх, мал хариулах зэрэг ажлыг хийж амьдрахаас өөр сонголтгүй болсноор сургуулиас завсардах нөхцөлийг бүрдүүлдэг байна¹⁸.
8. Монгол улсад хийгдсэн хүүхдийн сайн сайхан байдлын хамгийн сүүлийн судалгаа¹⁹нд хамрагдсан хүүхдүүдийн 4 хүүхэд тутмын 1 нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургуулийн орчин (сургуулийн коридор, анги, хичээлийн танхим, ариун цэврийн өрөө, биеийн тамирын заал гэх мэт хүүхэд олноор цугладаг газар) аюулгүй байдал алдагдсан, 3 хүүхэд тутмын 1 нь сургууль дээрээ үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртөж байсан гэж хариулт өгсөн. ДЭМБ-ын “Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлс” судалгааны үр дүнгээр батлагддаг. Тухайлбал 13-17 насны хүүхдүүдийн 39.6 хувь нь сүүлийн нэг жилд ноцтой осол гэмтэлд өртсөн, 23.3 хувь нь бусдад зодуулсан, 28.3 хувь нь бусадтай зодолдсон, 26.9 хувь нь сургууль дээрээ бусдад дээрэлхүүлсэн, 17.9 хувь нь цахим дээрэлхэлтэд өртсөн дүн гарчээ.²⁰
9. Цахим орчинд хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж байгаа шалтгаан, нөхцөлийг тодруулах зорилгоор улсын хэмжээнд санамсаргүй түүврийн аргаар хийсэн судалгаанд оролцсон 1699 хүүхдийн 16.4 хувь (280) нь цахим гэмт халдлагад өртөж байсан гэжээ. Цахим гэмт хэрэгт өртөж байсан гэх эдгээр хүүхдүүдийн 33.8 хувь нь мөнгө эд зүйлсээ залилуулсан, 19.0 хувь нь нууц үг хувийн мэдээллээ алдсан, 15.7 хувь нь зодуулж дээрэмдүүлсэн, 12.8 хувь нь садар самуунтай холбоотой гэмт хэрэгт өртөж байсан, 10.2 хувь нь гүтгүүлж, доромжлуулсан, 8.5 хувь нь дарамтад орсон гэж хариулжээ.²¹
10. Хөвгүүдийн дунд амиа хорлолт, хорт зуршилд автах нь өндөр. 2014 – 2018 оны хооронд амиа хорлосон хүүхдийн тоо 327, нас 5 – 19, үүний ихэнх нь эрэгтэй²².

17 Монгол улс дахь хүүхдийн хөдөлмөр: судалгааны үр дүн, 2021-2022 он

18 Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа, ХЭҮК, 2022 он

19 “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйл” үндэсний судалгаа, БШУЯ, ЭМЯ, ХНХЯ, 2023 он

20 Мөн тэнд

21 НҮБ-ын Хүүхдийн Сан. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам. УБ. 2021 он.

22 Жендэрийн суурь судалгааны тайлан, ЖҮХ, 2020 он, ҮСХ, Гадны шалтгаант нас баралтын өнөөгийн байдал, 2018 он

11. ШШГЕГ-ын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад байгаа хүүхдүүдийн дийлэнх нь боловсролын хоцрогдол, сургууль завсардалтад өртсөн хөвгүүд эзэлж байна. 50 гаруй хувь нь бэлгийн хүчирхийллийн гэмт хэргээр шийтгүүлж байна²³.
12. 1000 төрөлт тутмын 15.5 хувь нь 10-19 насны өсвөр насны охид эзэлж байна. Өсвөр насандаа жирэмсэн болсон охидоос 80% нь сургууль завсардаж, боловсролоос хоцрогддог²⁴
13. Албан боловсролд хэрэглэгдэж байгаа сурах бичигт эрэгтэй дүр, эх сурвалжууд давамгайлсан, эмэгтэй дүрүүд туслах, үл үзэгдэгч байдлаар дүрслэгдсэн. "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийн 6-12 ангийн сурах бичигт жендэрийн хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагыг бэхжүүлсэн утга, агуулгатай текст өргөн хэрэглэгдсэн. Нийгмийн бүлгүүд, ялангуяа хөдөөний иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, охид, эмэгтэйчүүд, үндэсний цөөнх, залуус цөөн эсвэл бараг дүрслэгдээгүй байгаа нь сурах бичгийн ач холбогдлыг хязгаарласан.²⁵
14. ЕБС-ийн биеийн тамир, технологийн хичээлүүд хүйсээр ялган хичээллэж байгаа нь жендэрийн хэвшмэл ойлголтыг улам бэхжүүлж, күйир²⁶ болон бусад сурагчдын мэргэжил сонголтыг жендэр байнари²⁷ хүйсийн хүрээнд хязгаарладаг.²⁸
15. Сургууль, боловсролын орчин жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцээгүй. Ялангуяа ариун цэврийн өрөө нь эрүүл ахуйн наад захын шаардлага хангадаггүй, ариун цэврийн цаас байхгүй, ариутгал цэвэрлэгээ тогтмол хийгддэггүй, бохир, агааржуулалтгүй, суралцагчид өдөрт уух зүйлээ хязгаарлах, шээсээ барих үүнээс үүдэн шээс-бөөрний замын үрэвсэл, охид эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үрэвсэлт өвчин тусах эрсдэл бий болж байна²⁹. Охидын эмч нар ариун цэврийн хэрэглэлийг 3-4 цаг тутамд сольж байхыг зөвлөдөг. Сургуульд байх үед хамгийн багадаа 1 удаа ариун цэврийн хэрэглэлийг солих шаардлага үүсч байна. Гэтэл судалгаанд оролцогчдын 57,5% нь нөхцөл байдлаас хамаарч чаддаг, 15,1% нь ариун цэврийн хэрэглэлээ сольж чаддаггүй гэжээ. Ариун цэврийн хэрэглэлийг солихгүй удаан хугацаанд байлгаснаар нян үржих таатай нөхцөл бий болж эвгүй үнэр гарах, шээс, үтрээний үрэвсэл үүсэх эрсдэл үүсдэг³⁰.
16. Багш нарын жендэрийн хэвшмэл ойлголт, тэр дундаа жендэрийн өрөөсгөл хүлээлт, үүнтэй холбоотой практик, үйлдлүүд нь маргинал

23 ШШГЕГ-ын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын тоон мэдээ, 2025 оны 3 дугаар сарын байдлаар, Боловсрол эвслийн мэдээлэл

24 "Хүүхэд төрүүлсэн өсвөр насны эхчүүдийн нөхцөл байдал" (чанарын судалгаа), Гүнж төв, 2023 он

25 "Иргэний ёс зүйн боловсрол" сурах бичигт хийсэн дүн шинжилгээ, ХЭҮК, 2022 он

26 Күйир- Хүйсийн баримжаа, илэрхийлэл болон, аль эсвэл бэлгийн чиг баримжааны хувьд давамгайллагч соёл, нийгмийн хэм хэмжээнд багтдаггүй хүмүүсийг нэрлэдэг толгой нэр томьёо.

27 Жендэр байнари- хүйсийг эрэгтэй, эмэгтэй хэмээх хоёр ангилалд хатуу зааглан тодорхойлсон тогтолцоо. Хүмүүсийн хүйсийн баримжаа нь төрөх үед тэмдэглэсэн хүйстэй, мөн хүйсийн илэрхийлэл, жендэрийн үүрэг нь соёл, нийгмийн хүлээлттэй нийцэж байх ёстой мэт үздэг үзэл.

28 "Сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөх байдал" судалгааны тайлангаас, "Хөөрхөн Зүрх" ТББ, 2024 он

29 "Охидын эрх ба ариун цэврийн өрөө" чанарын судалгаа, Охидын манлайллын хөтөлбөр төгсөгчдийн холбоо, 2024 он

30 Мөн тэнд, х-16

бүлгийн суралцагчдын хувьд сургуулиа орхих, сурлагын амжилтад нөлөөлөх нөхцөл бүрдүүлж байна. Сургуультай холбоотой хүчирхийлэл (зарим тохиолдолд жендэрт суурилсан) бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийлэл, бие махбодын шийтгэл зэрэг нь хүүхэд, өсвөр үеийнхний хувьд аюултай, айдас дүүрэн сургалтын орчныг бүрдүүлсэн хэвээр байна³¹.

- 17. Монгол улсад нийт 55.000 гаруй багш ажиллаж байгаагаас 45.190 нь эмэгтэй бөгөөд боловсрол дахь багшлах боловсон хүчний 82% эмэгтэй. Үүний 90 гаруй хувь нь СӨБ, ЕБС-ийн түвшинд ажилладаг. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд олноороо боловсролын салбарт ажиллаж байгаа нь хүүхэдтэйгээ хамт ажиллах боломжтой байдгаас шалтгаалж буй бөгөөд цалин хөлс бага ч хүүхэд асрах үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэгийн тогтолцоо³² харьцангуй үүссэн тул боловсролын салбарыг сонгон ажиллаж байна. “Эрэгтэй хүн өрхийн тэргүүний хувьд санхүүгийн ачааг илүүтэй үүрэх ёстой” гэсэн нийгмийн хэм хэмжээнд боловсролын салбарын цалин, үнэлэмж бага байгаа нөхцөлд эрэгтэй багш нар хувьд шалтгаалан карьер хөөх (сургуулийн захирал, сумын засаг дарга, иргэдийн хурлын төлөөлөгч гэх мэт), салбараас гарч өндөр цалин хөлстэй уул уурхай, барилгын салбар руу шилжих үзэгдэл үүсч байна.
- 18. “Охидын үзлэг” хэмээх үйлдлийг төрийн зүгээс ЕБС-ийн хичээлийн байр буюу зориулалтын бус газар хийж байгаа нь зөвхөн охидыг хүйсээс үүдэн онцлон ялган үзэж, нэгд, хөвгүүдийн нөхөн үржихүйн хэрэгцээг орхигдуулсан хүйсийн ялгаварлал болж, хоёрт, нөхөн үржихүйн асуудлыг зөвхөн охид, эмэгтэйчүүдэд илүүтэй хамаатуулах жендэрийн хэвшмэл үзлийг бэхжүүлэх хор нөлөөтэй³³.
- 19. Дотуур байранд амьдардаг сурагчид хичээлийн жилд 9 сар буюу жилийн 224-245 хоногт эцэг эх, асран хамгаалагчдаасаа хол дотуур байрны багш, тогооч, ажилтны асрамжид сурч хөгждөг байна. Дотуур байранд жил бүр 35000 хүүхэд хүсэлт гаргаж, түүнээс 33000 гаруй нь дотуур байранд амьдардаг. ЕБС-ийн дотуур байранд хийсэн судалгаагаар³⁴ өсвөр насны охидын ялгаатай хэрэгцээнд зориулж дотуур хувцсаа угаах, солиход зориулсан, хаалгаар тусгаарлагдсан угаалгын хэсэг бий болгосон 33 дотуур байр буюу судалгаанд хамрагдсан 137 дотуур байрны 24.1 хувийг эзэлж байна. Ариун цэврийн хэрэглэл болон бусад хогоо хаях тагтай хогийн савыг 70.1 хувь нь байршуулсан.
- 20. Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийг сургууль шилжүүлэх, үргэлжлүүлэн суралцуулах явцад хувийн нууц задрах, ялгаварлан гадуурхах асуудлууд үүсч, сургууль завсардах, сэтгэлзүйн дарамтад өртөх зэрэг эрсдэл үүсдэг³⁵.

31 ЕБС-ийн багшийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгаа, Боловсрол эвсэл, 2025 он

32 Цэцэрлэгт хүүхдээ өгөнгөө бүлгийн багш, туслах багш хийх боломж олддог. Мөн төрийн өмчийн сургуульд 3-5 жил ажиллаад хувийн сургууль руу хүүхдээ төлбөргүй сургах нөхцөлтэйгөөр шилждэг гэх мэт


33 “Охидын үзлэг” арга хэмжээ хүний эрх, хүүхдийн эрхийг зөрчиж байгаа тухай Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлгийн дүгнэлт, 2022 он

34 Дотуур байрны өнөөгийн байдал, хүчин чадлыг тодорхойлох судалгаа, БСҮХ, ЮНИСЕФ, 2024 он

35 Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн мониторингийн тайлан, 2022 он

21. Төрийн өмчийн их дээд сургуулиудын бодлогын баримт бичигт бэлгийн дарамтыг зохицуулах чиглэлээрх зүйл заалт нь багш, суралцагчийн хоорондын харилцаанд, эсвэл ажил олгогч ба багшийн хоорондын харилцаанд бэлгийн дарамтыг хориглоно гэх мэтээр бэлгийн дарамтыг хязгаарлагдмал хүрээнд тодорхойлсон байна. Бэлгийн дарамтын асуудал их дээд сургуулийн орчны ямар ч харилцаанд тохиолдож болох тул багш хоорондын, эсвэл багш, суралцагчийн хооронд гэх мэт хүрээгээр хязгаарлахгүйгээр их сургуулийн хөдөлмөр, сургалтын харилцаа, оюутны дотуур байр зэрэг өргөн хүрээнд тодорхойлох хэрэгцээ шаардлагатай. ХЭҮК-ын судалгаанд³⁶ суралцах хугацаандаа оюутнууд бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртөх явдал хэр тохиолддог тухай асуухад маш их гэж 7.6 хувь, их гэж 15.6 хувь, дунд зэрэг гэж 32.9 хувь, бага зэрэг гэж 27.2 хувь, огт үгүй гэж 16.7 хувь нь тус тус хариулжээ.

Зураг 3. Оюутнууд бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртөх тохиолдол



Сургуулийн өмчийн хэлбэрийн хувьд төрийн бус өмчийн буюу хувийн сургуулийн оюутнуудын дунд маш их (10%), их (20%) дунд зэрэг (36%) гэсэн хариулт нийлээд 66 хувийг эзэлж байгаа нь төрийн өмчийн сургуулийн оюутнуудын хариултын хувьтай (54%) харьцуулахад өндөр байна. Түүнчлэн хүйсийн хувьд бусад гэж хариулсан 3 оюутан бэлгийн дарамт хүчирхийллийн тохиолдлыг их ба дунд хэмээн үзсэн.

22. 15-19 настай өсвөр насны охид, хөвгүүд болон 20-24 насны залуучуудын ихэнх нь өөрсдийн дунд-ахлах ангид ордог “Эрүүл мэнд” хичээлээр олж авсан БНҮЭМ-ийн мэдлэгээ хангалтгүй гэж үнэлдэг. Энэ нь ихэнхдээ мэргэжлийн бус багш хичээл ордог, багшийн заах арга зүй муу, хичээлийн агуулга хэт ерөнхий, нарийвчилсан бус, охид хөвгүүдэд хамтад нь заадаг гэх мэт шалтгаантай холбоотой хэмээн дүгнэсэн³⁷.
23. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх хамгийн ихээр зөрчигддөг бүлгийг оюутнуудаар тодорхойлуулахад хамгийн олон давтамж бүхий гурван хариулт нь эмэгтэй (76.1%), хөгжлийн бэрхшээлтэй (37.5%), ЛГБТ (31.5%) гэсэн хариулт ирсэн. Энэ нь ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын хүрээнд цуглуулсан мэдээллээр давхар батлагдсан. Мөн аймаг, орон нутгаас ирж суралцаж буй оюутнуудын БНҮЭ зөрчигддөг гэж судалгаанд оролцогчдын 29.1% нь хариулснаас үзэхэд аймаг, орон нутгаас ирж суралцаж буй эмэгтэй оюутнуудын хувьд БНҮЭ нь илүүтэй зөрчигддөг байх магадлал өндөр.³⁸


36 “Их дууд сургуулийн оюутан залуусын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэг-жилт” судалгааны тайлан, ХЭҮК, 2023 он

37 Монголын Залуучуудын нөхцөл байдлын судалгаа, НҮБ-ХАС, 2024 он

38 Мөн тэнд

24. Оюутан, залуус бол хүн ам зүйн хувьд нөхөн үржихүйн насны бүлэгт харьяалагдах ба бэлгийн амьдралын чухал мөчлөгт амьдарч буй нийгмийн бүлэг. Тиймээс тэдний дунд үерхэж нөхөрлөх, бэлгийн харилцаанд орох, гэр бүл төлөвлөх, гэр бүлийн амьдрал үүсгэх, жирэмснээс хамгаалах арга хэрэглэх, бэлгийн замын халдварт өвчин тусах, түүнийгээ эмчлүүлэх, жирэмслэх, хүүхэд тээх, төрөх, хүүхэд асран хүмүүжүүлэх зэрэг бэлгийн ба нөхөн үржихүйн амьдрал идэвхтэй өрнөдөг. Багш, оюутнуудын зүгээс ялгаварлан гадуурхалтад өртдөг эсэхийг судлахад жирэмслэлт, төрөлттэй холбоотой (26.6 %), хүйсийн болон бэлгийн чиг баримжаатай холбоотой (25.4 %), үерхэл нөхөрлөлтэй холбоотой (24.1 %) ялгаварлан гадуурхалтанд өртдөг³⁹ хэмээжээ.





ГУРАВ. БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ КОНВЕНЦ, ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД

Энд онцолсон баримт бичгүүд нь жендэрийн эрх тэгш байдлыг боловсролын салбарт хангахыг чухалчлан, жендэрт суурилсан хүчирхийллийг шийдвэрлэхэд олон улсын болон бүс нутгийн түвшинд анхаарал хандуулж, улс орны Засгийн газрууд тодорхой хүчин чармайлт гаргаж буйг илтгэнэ.

№	Баримт бичиг	Зорилго	Гол агуулга	Ач холбогдол
1	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)	Жендэрийн тэгш байдлыг бүхий л салбарт хангах	Хүйсийн ялгаварлалтыг хориглох, төрийн үүргийг тодорхой заасан	<p>Монгол улсад анх удаа жендэрийн эрх тэгш байдлыг бүхий л шатанд хангах чиглэлээр ахиц дэвшил гаргасан хууль. Үүнд, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр агуулга тусаад зогсохгүй боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны тайланд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн, гарсан зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээг тусгах бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн нь сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг байна хэмээн 12.3 дугаар зүйлд заасан. Мөн тус хуулийн соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа бүлэгт тухайлан сурах бичиг, сургалтын материалыг жендэрийн эрх тэгш байдлыг үгүйсгэсэн агуулгатай байхыг хориглосон байна.</p> <p>12 дугаар зүйл. Соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа</p> <p>12.1. Эрэгтэй, эмэгтэй хүн сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших, албан ба албан бус сургалтад хамрагдах ба мэргэжил дээшлүүлэх, мэргэших, арга зүйн зөвлөгөө авах, мөн сургалтын тэтгэлэг авах тэгш эрх, тэгш боломжтой байна.</p> <p>12.2. Боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгчийн ажлын байр, сургалтын орчныг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгаж, жендэрийн сургалт, гэгээрлийн үйл ажиллагааг төлөвлөгөө, хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлнэ.</p> <p>12.3. Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны тайланд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн, гарсан зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээг тусгах бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн нь сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг байна.</p> <p>12.5. Ерөнхий боловсролын сургууль, сургалтын бусад байгууллагад хэрэглэдэг ном, сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүн нь жендэрийн эрх тэгш байдлыг үгүйсгэсэн агуулгатай байж үл болно.</p> <p>12.6. Насанд хүрсэн иргэн нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн боловсролын түвшний зөрүүг багасгахад чиглэсэн боловсрол нөхөн олгох албан ба албан бус сургалтад хамрагдах, тасралтгүй боловсролын үйлчилгээг хүртэх тэгш боломж, нөхцөлөөр хангагдана.</p>


3	Боловсролын тухай багц хууль (2023) (БЕХ, СӨБ, ЕБ-ын тухай хууль)	Хүүхэд, залуус/ суралцагч төвтэй буюу тэдний чадамжийг нээж, хөгжүүлэх гол үндсэн зорилгод анхаарч, сурч боловсрох эрхийг эдлүүлэхэд шаардлагатай бүх нөхцөлийг бүрдүүлэх	Насан туршдаа суралцахуй, суралцагч төвтэй хүмүүнлэг, тэгш хамруулах боловсролыг бүхий л шатанд	<p>Боловсролын салбарын процессыг хуульчилж, бодлогын төвд суралцагчийг оруулсан бөгөөд хүмүүнлэг хандлагаар боловсруулагдсан. Жендэрийн хувирган өөрчлөлт руу нэг алхам урагшлах боломжтой дараах заалтууд бий.</p> <p>3.1.24. "ялгаатай хэрэгцээ" гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг.</p> <p>10.1.1. эрүүл, аюулгүй, жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах;</p> <p>14.4. Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ:</p> <p>14.4.3. хүний эрхийн боловсрол, жендэрийн эрх тэгш байдал;</p>
4	Хүүхдийн эрхийн тухай хууль (2016)	Хүүхдийн эрхийг хамгаалах	Хөгжих, хамгаалагдах, оролцох эрх	Боловсрол, сургалтын орчин дахь хүүхдийн эсэн мэнд амьдрах, хүүхдийн хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох үндсэн эрхийн баталгаа болдог.
5	Хүүхэд хамгааллын тухай хууль (шинэчилсэн найруулга) (2024)	Хүүхдийг эрсдлээс хамгаалах	Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тогтолцоо	<p>23 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал</p> <p>23.1. Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв, сүм хийдийн шашны сургууль хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.</p> <p>23.2. Энэ хуулийн 23.1-д заасан байгууллагын орчин, дотуур байранд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>23.2.2. хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах;</p> <p>23.2.3. хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах нээлттэй суваг ажиллуулах;</p> <p>23.2.4. гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд холбогдсон болон хохирогч хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулах;</p> <p>Улмаар уг хууль нь сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх салбар дундын болон салбар хоорондын бодлогыг ойлгомжтой болгож, бодлого үйл ажиллагааны цөмд хүүхэд байхыг хуульчилж өгснөөрөө онцлог.</p>

6	Жендэрийн салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)	Жендэрийн тэгш байдлыг бүхий л салбарт дэмжих, салбар хоорондын уялдааг сайжруулах замаар жендэрийн тэгш байдлыг хангах	Боловсролын яам 1-р зорилгын хэрэгжилтийн хангахад анхаарна.	Зорилго 1. Охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэй хүмүүст эрүүл аюулгүй амьдрах, сурч боловсрох тэгш боломж бүрдүүлнэ. Онцлох зорилтууд 1.2.3 ЖЭТБХ тухай хуулийн 7-р зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар боловсрол (цэцэрлэг, багша ангийн багш)-ын мэргэжлээр суралцах эрэгтэй, ШУТИМ чиглэлээр суралцах эмэгтэй элсэгчдин эзлэх хувийг нэмэгдүүлэх 1.2.4 Бүх шатны боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт жендэр болон гэр бүлийн боловсролын агуулгыг суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулж тусгана. 1.2.9 Боловсролын үйлчилгээг жендэрийн агуулга, мэдрэмжтэй хүргэх, мэргэжил сонгол дахь жендэрийн хэвшмэл ойлголтын нөлөөг арилгах чадавхыг ерөнхий боловсролын сургуулийн багш нарт системтэй олгох, 1.2.10 ЕБС-ын суралцагчдыг ... жендэрийн хэвшмэл ойлголтоос сэргийлэх үйл ажиллагааг эцэг эх, багш, сурагчид (охид, хөвгүүд)-ын клуб, бүлгээр дамжуулан идэвхжүүлж дэмжих 1.2.12 Сургууль завсардсан охид, хөвгүүд, өрх толгойлсон залуу эмэгтэйчүүдийг дахин суралцуулах, мэргэжил олгоход дэмжлэг үзүүлэх
7	Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө	Салбарын дунд хугацааны хөгжлийг тодорхойлох бодлогын үндсэн баримт бичиг	Монгол хүний насан туршийн хөгжил, түүнийг дэмжих чанартай боловсролын тогтолцоог бэхжүүлэх 3 үндсэн чиглэл 1. Боловсролын чанар ба нийц, 2. Боловсролын хүртээмж, тэгш хамран сургалт, 3. Боловсролын засаглал, удирдлага, зохион байгуулалт	Боловсролын салбарыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн зорилтууд оруулсан. Ялангуяа СӨБ, МБСБ-ууд руу чиглэсэн бодлого, үйл ажиллагаануудад жендэрийн мэдрэмжтэй сургалтын хэрэглэгдэхүйн, мэргэжил сонголт, сургалтын хөтөлбөр, жендэрийн бодлого боловсруулах зэрэг үйл ажиллагаа төлөвлөгдсөн. Харин Ерөнхий боловсрол, дээд боловсролын түвшинд тэгш хамруулалт, хүртээмжийн агуулгад жендэрийн агуулга туссан гэж үзэж болохуйц. Жишээ нь, нүхэн жорлонг халах гэх мэт.
10	CEDAW (Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг олон улсын конвенц)	Эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулах, хамгаалах, урьдчилан сэргийлэх	Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг устгах	Охид, эмэгтэйчүүдийн хүний эрхийг зөрчиж, ялгаварлан гадуурхаж буйн нэг хэлбэр хэмээн буруушааж буй жендэрт суурилсан хүчирхийллийн аливаа тохиолдлоос урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, яллах, шийтгэх талаар гарын үсэг зурсан талууд зэрэг арга хэмжээ авах ёстойг баталгаажуулсан.
	Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц (1960)	Боловсролын салбарт ялгаварлан гадуурхалтыг хориглож, бүх хүнд тэгш боломж олгох		Улс орнууд алагчлалыг хориглох, хүн бүр боловсрол эзэмших эрхтэй байх зарчмыг хүлээн зөвшөөрсөн. Мөн аюулгүй, хүчирхийллээс ангид сургалтын орчин нь чанартай боловсролын чухал хэсэг болохыг хүлээн зөвшөөрсөн. Боловсрол нь бүгдэд нээлттэй, хүртээмжтэй байх, бага боловсрол үнэ төлбөргүй байх, охид хөвгүүд ижил тэгш эрхтэй суралцах боломжоор хангагдах ёстойг хүлээн зөвшөөрсөн баримт бичиг.

11	Хүүхдийн эрхийн конвенц (1989)	Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хэрэгжүүлэх	Боловсрол, хамгаалал, оролцоо	<p>Конвенцид хүүхдийг хүйсээр ялгаварлахгүй байх, охид, хөвгүүдэд тэгш боломж олгох, Жендэрийн тэгш байдлыг бүх эрхэд нэгтгэн хэрэгжүүлэхийг баталгаажуулсан.</p> <p>Хүүхдийг эцэг эх болон асран халамжилж буй хүмүүсийн зүгээс үйлдэгдэж буй аливаа хүчирхийлэл, үл хайхрах байдлаас хууль ёсоор хамгаалахыг улс орнуудад үүрэг болгосон. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> o Хүүхдийг хамгаалах хууль, бодлого хэрэгжүүлэх o Эцэг эх, асран хамгаалагчдад дэмжлэг үзүүлэх o Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх o Хохирсон хүүхдэд тусламж, хамгаалалт, сэргээн засах үйлчилгээ үзүүлэх
	"Боловсролыг бүх нийтэд" Дакарын үйл ажиллагааны хүрээ (2000)	Бага насны хүүхдийн боловсролыг өргөжүүлэх (ялангуяа эмзэг бүлгийн хүүхдүүд рүү чиглэх), Залуучууд, насанд хүрэгчдэд суралцах боломж олгох (амьдрах ур чадвар) Насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролыг нэмэгдүүлэх, Жендэрийн тэгш байдлыг хангах	Боловсролыг хүний үндсэн эрх гэж баталгаажуулсан. Ядуу, эмзэг бүлгийн хүүхдүүдийг боловсролд хамруулахад бодлогын анхаарал хандуулсан. Хүйсийн ялгаа (жендэрийн тэгш бус байдал)-г арилгахыг онцолсон.	<p>Дэлхийн бүх хүүхдэд сайн чанартай, үнэ төлбөргүй бага боловсролыг олгох хүрээнд батлагдаж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зургаан зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгасан.</p> <p>Дакарын үйл ажиллагааны хүрээ нь хүчирхийлэл, зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй сургалтын орчныг бүрдүүлэх зэрэг "Боловсролыг бүх нийтэд!" зорилгод хүрэх гол стратегийг тодорхойлсон. Дакарын үйл ажиллагааны хүрээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Боловсролыг бүх хүнд хүртээмжтэй болгох (ялангуяа маргинал бүлгийнхэнд) • Жендэрийн тэгш байдлыг хангах (тухайлбал, сургууль завсардалтыг бууруулах, эрт гэрлэлт, гэрийн ажил зэрэг саад бэрхшээлийг багасгах, хөвгүүдийн хөдөлмөр эрхлэлтэд анхаарах, сургалтын орчинд хүйсээр ялгаварлахгүй байх, сургалтын материал, дидактик арга зүйд жендэрийн тэгш байдлыг тусгах, хүүхдийн хүчирхийлэл, дарамтаас хамгаалах, охид хөвгүүдэд аюулгүй сургууль бий болгох зэрэг) • Чанартай боловсролыг хөгжүүлэх чиглэлээр дэлхийн улс орнуудад нэгдсэн зорилго, бодлогын суурь болсон юм.

	Инчеоны тунхаглал	Тогтвортой хөгжлийн зорилт 4 хэрэгжилтийг дэмжих "Хүн бүрт хүртээмжтэй, тэгш, чанартай боловсрол олгож, насан туршийн суралцах боломж"	Боловсролыг хүн бүрийн эрх гэж баталгаажуулсан. 2030 он хүртэл боловсролын хөгжлийн дэлхийн зорилтыг тодорхойлсон. Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол болон насан туршийн суралцахуйг онцолсон.	"Боловсрол 2030: Бүх нийтэд хүртээмжтэй, тэгш чанартай, насан туршийн боловсролын төлөөх" баримт бичгийг баталсан. 8 дугаар зүйлд: "Бүх нийтийн боловсрол эзэмших эрхийг хангахад жендэрийн тэгш байдал чухал болохыг бид хүлээн зөвшөөрч байна. Тиймээс бид жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, сургалтын орчныг дэмжих; багш бэлтгэх тогтолцоо, сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах; мөн сургуулиуд дахь жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг арилгах чиглэлээр үүрэг хүлээнэ" гэдгийг баталгаажуулж, ТХЗ 4 "Хэнийг ч үл үлдээх чанартай боловсрол" -ын суурь болсон. ТХЗ 4 нь бусад 16 зорилгын хурдасгагч нь юм.
	Айдасгүй суралцахуй санаачилга (2024)	ЮНЕСКО-гийн энэхүү санаачилга нь сургуулийн орчныг хүүхэд бүрт аюулгүй ээлтэй, хүчирхийлэлгүй итгэлцэл дүүрэн, дэмжлэг бүхий орчин болгох зорилготой, олон улсын бодлогын чиг баримжаа юм.	Бүх хүүхдэд: • Аюулгүй • Хүндэтгэлтэй • Айдасгүй суралцах орчинг бүрдүүлэх	58 гишүүн орноос бүрдсэн ЮНЕСКО-гийн Гүйцэтгэх зөвлөл бүх хүүхдэд аюулгүй, тэгш хамруулсан, хүртээмжтэй, чанартай сургалтын орчныг дэмжих үндэсний бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн "Айдасгүй суралцахуй" шийдвэрийг гаргасан. СХЖСХ-ийн талаарх НҮБ-аас гаргасан энэхүү шийдвэр нь хүүхдийн эрүүл мэнд, суралцахуй, сургуульд хамрагдах, сургуулиа төгсөхөд үзүүлэх сөрөг үр дагаврыг анх удаа хүлээн зөвшөөрсөн. Энэхүү баримт бичиг нь: • Сургуулийн орчинд гарч буй хүчирхийлэл, дарамт, ялгаварлал-ыг бууруулах • Хүүхдийг айдасгүй, тайван орчинд суралцах боломжтой болгох • Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зорилготой.
12	Тогтвортой хөгжлийн зорилт (SDG 4, 5)	Тогтвортой хөгжлийг хангах	Чанартай боловсрол, Жендэрийн тэгш байдал	ТХЗ-ын 4-т "Бүх хүнд аюулгүй, хүчирхийлэлгүй, тэгш хамруулсан, ялангуяа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй боловсролын тогтолцоог бий болгох, үр дүнтэй суралцахуйн орчныг бүрдүүлэх" чиглэл багтсан болно. Мөн 4.7 Дэлхийн иргэний боловсролын агуулгад "... жендэрийн тэгш байдал, охид эмэгтэйчүүдийн эрх мэдэлжилт, хүчирхийллийг таних, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчил шийдвэрлэх" агуулгуудыг тусгах зорилт ⁴⁰ багтсан. Зорилго 16-д "Хүчирхийллийн бүх хэлбэр, түүнтэй холбоотой нас баралтыг хаа сайгүй бууруулна" зорилтыг багтаасан болно. Зорилго 5-д жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд, охидыг эрхмэдэлжүүлэх, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох, олон нийтийн болон хувийн орон зай дахь эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгах зэрэг зорилтууд багтсан.

40 "ТХЗ 4 дүгээр зорилгын хэрэгжилт" Иргэний нийгмийн тодруулагч тайлан, Боловсрол эвсэл, 2019 он



ДӨРӨВ. ЖЕНДЭРИЙН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ БОЛОВСРОЛ

Боловсрол нь улс орнууд дахь шударга бус, тэгш бус байдлыг эсэргүүцэж, хүнийг хүн шиг амьдрахад саад болж буй бэрхшээлүүдийг арилгах замаар нийгэмд хувирган өөрчлөлт хийх хүчтэй. Боловсрол энх тайван, шударга ёс, эрх тэгш ертөнцийг бий болгохын тулд дарангуйлагч тогтолцоог нураахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, үнэт зүйл, хандлагыг төлөвшүүлж чаддаг. Хүн бүр өөрийн айдентитигээс үл хамааран мөрөөдлөө биелүүлж, эрхэм чанартай төдийгүй баяр баясгалантай амьдрах эрхтэй. Хүүхэд, залуучууд ялгаатай хэрэгцээндээ нийцсэн ээлтэй, чанартай, үр бүтээлтэй боловсрол эзэмших эрхтэй.

Жендэрийн хувирган өөрчлөлт хийх боловсрол нь зөвхөн боловсролд тэгш хүртээмжтэй байх тухай биш юм. Энэ нь бидний заах арга зүй, суралцах арга барилыг хувьсгал хийх тухай ойлголт юм. Энэ нь хор хөнөөлт, хуучирсан жендэрийн хэвшмэл ойлголтыг эсэргүүцэх, ялгаварлан гадуурхах эрх мэдлийн тогтолцоог задлах тухай юм. Энэ нь суралцагчдыг анги танхимд амжилттай суралцах, анги танхимаас гадуур зорилго, мөрөөдлөө биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх тухай юм.

Энэхүү алсын харааг бодит болгохын тулд бид байгууллагууд болон идэвхтнүүдийг дэмжихийн зэрэгцээ боловсролын салбарт эрх мэдэл хэрхэн бүтэцлэгдэж, хэнд төвлөрч, хэрхэн хэрэгждэгийг гүнзгий ойлгох шаардлагатай. Эрх мэдлийн динамик нь бодлого боловсруулах, нөөц хуваарилах, шийдвэр гаргах үйл явцад хэн оролцож, хэний дуу хоолой сонсогдож, хэний хэрэгцээ үл тоомсорлогдож байгааг илэрхийлдэг.

Гол шийдвэр гаргагчид болон нөлөө бүхий оролцогч талуудыг тодорхойлох нь зөвхөн тэднийг таних төдий бус, харин тэдний албан ёсны эрх мэдэл, албан бус нөлөөлөл, ашиг сонирхол, хариуцлагын механизмыг шинжлэх явдал юм. Ингэснээр эрх мэдлийн тэнцвэргүй байдал хэрхэн хадгалагдаж буйг илрүүлж, эмэгтэйчүүд, охид болон бусад ялгаварлан гадуурхалтад өртдөг бүлгүүдийн оролцоог хязгаарлаж буй саад бэрхшээлийг тодорхой харж чадна.

Эдгээр эрх мэдлийн харилцааг ойлгож, зорилтот байдлаар нөлөөлөх стратеги боловсруулах нь өөрчлөлтийг идэвхжүүлж, хурдасгах үндэс болдог. Улмаар байгууллагын дотоод бүтэц, бодлого, нийгмийн хэм хэмжээ, шийдвэр гаргах соёлыг өөрчлөх замаар эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг даван туулж, бодит оролцоо, хариуцлага, тэгш боломжид суурилсан жендэрийн хувирган өөрчлөлтийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.1 БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ЖЕНДЭРИЙГ НЭГТГЭСЭН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

4

Боловсролын бодлого бол энэ жендэрийн хувирган өөрчлөлтийн хамгийн гол талбар бөгөөд хүмүүсийн итгэл үнэмшил, хандлага, зан үйлийг төлөвшүүлж, ирээдүйн нийгмийн бүтэц, харилцааг бий болгодог. Иймд боловсролын бодлого нь жендэрийн тэнцвэрт байдлыг хангах биш, тэгш бус байдлыг бий болгодог суурь шалтгаануудыг хувирган өөрчлөх чиглэлтэй байх ёстой гэж ИНБ-ууд үзэж байна.

Жендэрийн хувирган өөрчлөлт хийх хандлага, арга зүй нь жендэрийн тэгш бус байдлыг танин мэдэх, зөвхөн нөхцөл байдал сайжруулах түвшинд зогсохгүй, харин бүтцийн өөрчлөлт хийж, нийгэм, институт, сургалтын орчинд тогтсон эрх мэдлийн харилцаа, хэвшмэл ойлголт, бүтэц, соёлыг өөрчлөх зорилготой цогц стратеги.

Монгол Улсын Үндсэн хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Боловсролын Ерөнхий хууль болон “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022–2031)” зэрэг үндэсний хууль, бодлогын баримтууд нь боловсролын тогтолцоонд жендэрийн мэдрэмжтэй, хувирган өөрчлөх бодлого хэрэгжүүлэх суурь үндсийг бүрдүүлж байна. Мөн Тогтвортой хөгжлийн зорилго–2030 (ТХЗ) нь охид, хөвгүүдэд эрх тэгш, тэгш хамарсан, чанартай боловсрол олгох зорилтуудад хүрэх амлалт авсан.

Дээрх эрх зүйн болон бодлогын орчин нь боловсролын салбарын бодлого, төлөвлөлтийг олон талт ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлыг бууруулах, жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, хүүхдийн эрхийн зөрчлийг таслан зогсоох, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, маргинал бүлгийн хүүхдүүдийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд тогтолцоог бүхлээр нь өөрчлөх шаардлагатайг харуулж байна.

Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон түншүүд боловсролын тогтолцоонд буй жендэрийн саад бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг анги танхимд, багшийн боловсрол болон дадлага, сургалтын хөтөлбөр, материал болон манлайлал, удирдлага гэсэн чиглэлээр шийдвэрлэх стратеги, бодлого боловсруулах нь чухал.

Түүнчлэн албан ба албан бус боловсрол эсвэл мэргэжлийн сургалтаар дамжуулан маргиналчлагдсан бүлгүүдэд хүрэхэд тулгарч буй бэрхшээлийг шийдэхэд нотолгоонд суурилсан бодлого чухал байдаг. Мөн зөрчилдөөн, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг зэрэг онцгой болон тодорхойгүй байдлын үед жендэрийн хувирган өөрчлөх боловсролыг дэмжих тусгай бодлого боловсруулах шаардлагатай. Салбар дундын бодлого нь боловсролоос зохистой ажлын байр руу шилжих явцад охидод тулгарч буй бэрхшээл, эмэгтэйчүүдийн ШИМТ-ийн оролцоог нэмэгдүүлэх, бүх нийтийн цахим хүртээмжийг хангах зэрэг чухал асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Боловсролын салбар дахь жендэрийн бодлого нь зөвхөн эрх тэгш боломж олгохоос цааш нийгмийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, эрх мэдлийн харьцааг тэнцвэржүүлэх зорилго руу чиглэх шаардлагатай.

4.2 ЖЕНДЭРИЙН ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛДЭГ СУРАЛЦАХУЙН ОРЧИНД ТАВИГДААГ МИНИМАЛ СТАНДАРТ

Жендэрийн хариу үйлдэл үзүүлдэг суралцах орчин нь охид, хөвгүүд болон бүх суралцагчдад аюулгүй, тэгш, хүртээмжтэй, ээлтэй орчинг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой⁴¹.

Жендэрийн хариу үйлдэл үзүүлдэг сургуулийн орчин дараах шаардлагыг хангасан байна.

4

Аюулгүй, ялгаварлан гадуурхалгүй орчин бүрдүүлэх чиглэлээр⁴²

- Сургуулийн хичээлийн байр, дотуур байр, биет орчин (анги, ариун цэврийн өрөө, цайны газар, номын сан г.м.), болон цахим орчин бүх сурагчдад бие махбодын болон сэтгэлзүйн хувьд аюулгүй байх
- Сургуулийн дотоод дүрэм, журам болон хариуцлагын арга хэмжээ нь жендэрийн ялгаварлан гадуурхалтгүй, шударга байх
- Жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамтын эсрэг урьдчилан сэргийлэх тогтолцоо бүхий мэдээлэх системтэй байх

Ариун цэврийн байгууламжтай байх чиглэлээр⁴³

- Охид, хөвгүүд, транс сурагчид болон хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын ялгаатай хэрэгцээнд тохирсон ариун цэврийн байгууламж нь цэвэр, аюулгүй, дулаахан, гэрэлтүүлэгтэй байх, нүхэн жорлонг бүрмөсөн халахад чиглэх, (тухайлбал, охидын ариун цэврийн өрөө хөвгүүдийнхээс тооны хувьд илүү байх, хүйсийн ялгаагүй ариун цэврийн өрөө болон, хувцас солих өрөөтэйгээр төлөвлөх, дэд бүтцэд оруулах гэх мэт)

Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэх

- Ерөнхий боловсролын дотуур байранд 6 настай хүүхэд гэр бүлээсээ хол амьдарч эхэлдэг учир хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтайгаа уулзах, хамт хонох, гэр бүлийн уур амьсгал бүрдүүлсэн өрөө, тасалгааны орчин бүхий дотуур байрыг төлөвлөх, улмаар хүйсээр ялган тусдаа байрладаг дотуур байртай болох (өөр өөр давхарт бус тусдаа байр байх)
- Сарын тэмдгийн үеийн эрүүл ахуйн хэрэгцээг хангах, нөхөн хангалт тасралтгүй хийх сургуулийн дотоод зохицуулалтыг бий болгох, санхүүжилт тогтвортой, тогтмол хяналттай байх (байнгын ариун цэврийн хэрэгслийн хайрцаг, аюулгүй, тайван орчин гэх мэт)

41 UNGEI & UNESCO 2015). School-Related Gender-Based Violence: Global Status Report

42 UNESCO - Behind the Numbers: Ending School Violence and Bullying, 2019

43 WHO & UNICEF, WASH in Schools: Empirical Evidence and Lessons Learned from 14 Countries, 2018

4.3 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, СУРАХ БИЧИГ, СУРГАЛТЫН МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ ЗАРЧИМ

4

Судлагдахуун бүрийн сургалтын хөтөлбөрт жендэрийн эрх тэгш байдлыг тусгах: Жендэрийн эрх тэгш байдал зөвхөн «нийгмийн ухаан» эсвэл «ёс зүй» гэх мэт хичээлд тусгах байдлаар хязгаарлагдахгүй. Харин бүх хичээл – математик, шинжлэх ухаан, уран зохиол, технологи гэх мэт агуулгад бодит амьдралд хүйсээс үл хамааран хүн бүр тэгш оролцох боломжтой гэдгийг харуулсан агуулга (бичвэр болон зураг) оруулснаар хүүхдүүдийн хандлага, үнэлэмж илүү эрх тэгш болж төлөвшдөг⁴⁴.

Сурах бичгийг жендэрийн шинжээчдийн тусламжтайгаар хянаж, хэвшмэл дүр төрхөөс ангид боловсруулах: Сурах бичигт дүрслэгдэж буй текст, дүр зураг, мэргэжлийн төлөөлөл, үүрэг роль зэрэгт хүйсийн тэнцвэрт оролцоог тусгах нь хүүхдийн сэтгэлгээ, хандлагын суурь болж өгдөг. Хэрвээ зөвхөн эрэгтэйг эрдэмтэн, эмэгтэйг асрагч мэтээр дүрсэлбэл хүүхдүүдийн хүйсийн талаарх төсөөлөл ташаа тогтох аюултай. Тиймээс жендэрийн шинжээчийн дүгнэлт, хяналтыг тогтмолжуулах хэрэгтэй⁴⁵.

Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах шатанд зохиогч, редактор, зураачид жендэрийн мэдрэмжтэй байх сургалтад хамрагдсан, охид хөвгүүдийг тэнцвэртэй дүрсэлсэн зураг, жишээ, бичвэр, агуулгад жендэрийн шинжээч хянан баталгаажуулдаг тогтолцоотой байна.⁴⁶

Амьдрах ухаан, нөхөн үржихүй, бэлгийн цогц боловсролыг агуулгадаа тусгах: Хүүхэд бүр нөхөн үржихүйн эрх, аюулгүй байдал, харилцааны ёс зүй, хүчирхийлэл гэж юу болох, өөрийгөө хэрхэн хамгаалах талаарх үнэн зөв, насандаа тохирсон мэдлэгтэй байх нь урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга юм. Энэ мэдлэг нь суралцагчдад өөрийн болон бусдын эрхийг хүндэтгэх хандлага, шийдвэр гаргах ур чадварыг төлөвшүүлдэг⁴⁷.

Хөтөлбөр боловсруулах шатанд олон нийтийн болон мэргэжлийн оролцоог хангах: Сургалтын хөтөлбөр боловсруулалт нь зөвхөн төрийн байгууллага дотооддоо боловсруулдаг биш, харин багш, сурагч, эцэг эх, мэргэжлийн холбоо, ИНБ зэрэг олон талт утга учиртай оролцоонд суурилсан байх нь илүү бодит хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй бодлого болдог. Мөн энэ оролцоо нь хүүхдийн дуу хоолойг сонсох ардчилсан соёлын төлөвшилд ч нөлөөлдөг⁴⁸. Сургалтын хөтөлбөрийн бодлого төлөвлөлтийн шатанд удирдах багийн гишүүдийн жендэрийн харьцаа тэнцвэртэй байх, охид, хөвгүүдийн ялгаатай хэрэгцээг тусгасан байх, багийн гишүүд жендэрийн тэгш байдлыг үндсэн сургалтад хамрагдсан байх, сурагчдын оролцоотойгоор хөтөлбөр, сурах бичгийн агуулгыг туршиж, үнэлж байх тогтолцоог бүрдүүлнэ⁴⁹.

44 UNESCO "Gender in Education Curriculum and Learning Materials" 2019

45 UNESCO & Commonwealth Secretariat "A Guide for Gender Equality in Teacher Education Policy and Practices." 2015

46 Promoting Gender equality in education, UNESCO, 2009

47 "Comprehensive Sexuality Education for Gender Equality and Empowerment" UNFPA, 2022

48 "Guidance for Developing Gender-Responsive Education Sector Plans." GPE & UNGEI 2017

49 Promoting Gender equality in education, UNESCO, 2009

Жендэрийн хувирган өөрчлөгч сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад дараах байдлаар анхаарна. Үүнд:

Жендэрийн хяналт-шинжилгээ хийх аргачлал нэвтрүүлэх

Сургалтын хөтөлбөр болон сурах бичиг боловсруулахын өмнө хүйсийн хувьд аль бүлэгт давуу болон сул байр суурь үүсэж байгааг тодорхойлох жендэрийн хяналт-шинжилгээ хийх шаардлагатай. Хяналт-шинжилгээнд хүйсийн тэнцвэр, дүрслэл, хэллэг, сурагчдын оролцооны боломж, хэрэглэгдэхүүний хүртээмж зэрэг үзүүлэлтийг ашиглана. Хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэх бүрд энэхүү хяналт-шинжилгээг давтан хийж тогтолцооны түвшинд сайжруулах,

4

Жендэрийн шалгуур үзүүлэлт бүхий стандарт хэрэглэх

Сургалтын хөтөлбөр болон сурах бичгийн агуулгыг хүлээн авах, хянан баталгаажуулах үе шатанд жендэрийн хариу үйлдлийн шалгуур (gender-responsive criteria)-ыг албан ёсны баримт бичигт тусгана. Эдгээр шалгуурт текст, зураг, үүрэг дүр, мэргэжлийн төлөөлөл, хэл найруулга, бодлого дахь оролцогч талуудын тэнцвэр, хандлага төлөвшүүлэх зорилт зэрэг үзүүлэлтийг тусгаж, шалгуурын дагуу үнэлгээ хийдэг стандарттай байх

Оролцоонд суурилсан боловсруулалт

Багш, эцэг эх, асран хамгаалагч, сурагч, жендэрийн шинжээч, ИНБ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төлөөлөл зэрэг олон талт оролцоог ханган, боловсруулалтын бүхий л үе шатыг нээлттэй байлгах,

Суралцагчдын дуу хоолойг системтэй сонсох зорилгоор ярилцлага, анкет, хэлэлцүүлэг зохион байгуулах,

Агуулгыг турших үе шатанд оролцогч талуудын санал хүсэлтийг судалгааны аргаар авч, сайжруулалтыг нотолгоонд суурилан хийх,

Багш, зохиогч, редакторуудыг жендэрийн хувирган өөрчлөх хандлага, арга зүйтэй болгох

Хөтөлбөр, сурах бичгийн зохиогчид болон редакторуудыг жендэрийн ойлголт, жендэрт суурилсан хэвшмэл ойлголт, хүүхдийн хөгжлийн онцлог болон хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтад тогтмол хамруулах,

Зураач, дизайнерууд, зохиогчдод сурах бичгийн дүрслэлийн жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг заавал мөрдүүлэх техникийн гарын авлага гаргаж, дагаж мөрдөхийг шаардах,

Хэрэгжилтийн үеийн хяналт-шинжилгээ, үнэлгээний жендэрийн үзүүлэлтүүдийг тогтоох

Сургалтын хөтөлбөр хэрэгжих үе шатанд хүйсийн тэнцвэртэй оролцоо, сурагчдын хандлагын өөрчлөлт, жендэрийн хэвшмэл ойлголтыг бууруулах үр дүнг хэмжих хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт боловсруулах,

Хэрэгжилтийн явцад сургууль, багш нарын түвшний ХШҮ хийж, жендэрийн зөрүү илэрсэн тохиолдолд засварлах арга хэмжээ боловсруулдаг тогтолцоог бүрдүүлэх,

4.4 БАГШЛАХУЙ БА ЖЕНДЭРИЙН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ

Багш бол жендэрийн хувирган өөрчлөх боловсролын элч юм. Тиймээс өөрчлөлтийн элч болохын тулд өөрсдийгөө хувирган өөрчлөх шаардлагатай. Сайн боловсролын тогтолцооны тулах нуруу нь багш. Нийгэм багш нарыг хэрхэн харж үнэлдэгтээ, багш нар өөрийн үүргээ хэрхэн биелүүлэх, хариуцлагаа хэрхэн хүлээхдээ суурь өөрчлөлт хийх шаардлагатай.

4

Багш босоо, ганц чиглэлт зааварчилгаанаас татгалзаж, идэвхтэй хамтран ажиллах чиглэлд мэдлэг бүтээгч, чиглүүлэгч, хөтөч болж өөрчлөгдөх шаардлагатай. Өмнөх туршлагад болон судлан шинжлэхэд суурилсан, сониуч зандаа хөтлөгдөн сурахад, чадавхиа хөгжүүлэх, асуудлыг шийдэхийн баяр баясгалан, сахилга батад суралцах боломж олгосон суралцахуйг хөхиүлэн дэмжих, үйлдэл хийх шаардлагатай болно. Багш бэлтгэх тогтолцооноос эхлээд анги танхим дахь багшийн дүр, практик ажиллагаа жендэрийн хариу үйлдэл үзүүлдэг болж өөрчлөгдөх шаардлагатай. Багшийн сургалт, мэргэжлийн хөгжлийн талаар цогц бодлого, практик хэрэгжиж, тэдний сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлж байж үр дүн гаргана.

Багш бэлтгэх, ажилд авах асуудалд анхаарах: ЮНЕСКО-ийн мэдээлснээр ТХЗ 4-ийг хэрэгжүүлэхийн тулд дэлхий даяар дор хаяж 69 сая багш шаардлагатай гэж мэдээлсэн. Багш нарыг ажилд авахад шалгуур тавих, тэдэнд шударга, өрсөлдөхүйц цалин хөлс олгох, ажиллах таатай орчин бүрдүүлэх, ажлын ачааллыг зохистой түвшинд барих, мэргэжлийн хувьд тасралтгүй хөгжих боломжийг хангахыг шаардаж байна. Багш нарыг жендэрийн хувирган өөрчлөх сургалт болон XXI зууны боловсролын шинэ сургалтын хөтөлбөрөөр тасралтгүй бэлтгэх нь суралцагчдад хүртээмжтэй, тэгш хамруулсан, чанартай боловсрол олгоход дэмжлэг үзүүлнэ. Багш жендэрийн талаар илүү мэдлэг ойлголттой болох, бүх хүйсийн ялгаатай хэрэгцээг ойлгож, шийдвэрлэх ур чадвар эзэмшүүлэх, сургалтын хөтөлбөр, сурах бичигт байгаа жендэрийн хэвшмэл, өрөөсгөл ойлголтуудыг залруулах, охид, хөвгүүдийн тэгш эрх, оролцоог анги болон сургуулийн олон нийтийн дунд бий болгох багшлахуйн дадал, аюулгүй орчинд суралцах эрхийг хангах зэрэг агуулга багш нарын сургалтад багтах ёстой. Мөн цахим орон зайд охид, эмэгтэйчүүдийг тэгш хамруулахад учирч буй саадыг арилгах, ШИМТ сургалтад охид, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эрт жирэмслэх, гэрлэхээс урьдчилан сэргийлэх, болон шилжилт хөдөлгөөний боловсролд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах асуудлыг багтаах нь зүйтэй.

Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн хувирган өөрчлөх хандлага, арга зүйг тусгах: Багш бэлтгэх бодлого, төлөвлөлтийн шатнаас нь эхлэн жендэрийн эрх тэгш байдалд анхаарах нь сургалтын орчинг аюулгүй, эрх тэгш, бүгдэд ээлтэй орчин бий болгоход тусалдаг.

Багш нар өөрсдийн жендэрийн хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагаа шалгаж, тодорхойлон өөрчлөх, анги доторх тэгш бус байдлыг илрүүлэн сөрөн зогсох чадвартай байх ёстой.

Хүснэгт 1. Багш бэлтгэх сургалт, багшийн өдөр тутмын үйл ажиллагаанд
жендэрийн хувирган өөрчлөлтийг нэвтрүүлэх нь

Багш сургууль, анги танхимын орчинд жендэрийн эрх тэгш байдалд анхаарах	<ul style="list-style-type: none"> • Хүн бүрийн сурах чадвар хүйсээс үл хамаарна гэдгийг ухамсарлах • Охид, хөвгүүдийн оролцоо, өөртөө итгэх байдалд жендэрийн хэвшмэл ойлголт нөлөөлдгийг таних • ШИМТ салбарт охид дэмжих, хөвгүүдийн зөөлөн ур чадварыг дэмжих • Сурагчдын суралцахад тулгарч болох жендэрийн саад бэрхшээлийг ажиглан анзаарч чаддаг байх
Багш хичээлийн агуулга, хэрэглэгдэхүүн дэх ялгаварлан гадуурхалтын нөлөөг таньдаг байх, сөрдөг байх	<p>Зураг, жишээ, агуулгад нэг хүйс хэт давамгайлахаас сэргийлэх, аль нэг хүйсийг сул дорой, идэвхгүй дүрээр харуулахгүй байх</p> <ul style="list-style-type: none"> • Жендэрийн хэвшмэл ойлголт агуулсан үг хэллэг хэрэглэхээс сэргийлэх (байгалиасаа охид уян зөөлөн, даруу төлөв, хөвгүүд зоригтой, эрмэг гэх мэт) • Зааж буй хичээлийн агуулгад эмэгтэй/эрэгтэй хүмүүсийн тэнцвэртэй төлөөлөл тусгахад анхаарах (зохиолчид, эрдэмтэд, түүхэн хүмүүс гэх мэт) • Асуудал шийдвэрлэх, хэлэлцүүлгийн асуултуудыг боловсруулахдаа жендэрийн хариуцлагатай байх • Хөвгүүд зөвхөн техник, охид зөвхөн бичих, ярих, асрах гэх давтагдсан хэвшмэл үргийг задалж өөрчлөх, шүүмжлэлтэй хандах, сөрөх • Жендэрийн хэвшмэл ойлголтыг эвдсэн даалгавар, кейс боловсруулах
Анги танхим дахь суралцагч хоорондын харилцааг ажиглах	<ul style="list-style-type: none"> • Аль нэг хүйсийн оролцоог давамгай байлгах бус ижил тэгш оролцуулахад анхаарах • Бүлгийн ажилд хүйсийн дагуу үүрэг хуваарилагдах явдлыг анзаарч, зайлсхийх • Нөхөрсөг бус, ялгаварлан гадуурхсан, дарамт, дээрэлхэлттэй харилцааг таньж таслан зогсоох арга хэмжээг нэн даруй авдаг байх
Оролцоог тэгш хангах арга зүй	<ul style="list-style-type: none"> • Бүх суралцагчдыг ээлжилж нэрлэн дуудаж, оролцоог тэгш хангах • Бүлгийн ажлын үеэр манлайлах боломжийг охид хөвгүүдэд ээлжлэн олгох • Дуугүй, бүрэг ичимхий, хичээл сургалтын үйл ажиллагаанаас хойш суух хандлагатай сурагчдыг оролцоонд татах тактик ашиглах
Аюулгүй, ялгаваргүй орчныг бүтээх	<ul style="list-style-type: none"> • Хүчирхийлэл, дарамт, ялгаварлалын эсрэг сургууль, анги танхимын дүрэм, журам тогтооход манлайлах • Сэтгэлзүйн аюулгүй байдлыг хангах (алдаанаасаа айхгүй суралцах, хичээл зүтгэл гаргах тэмүүлэл бүхий орчин бүрдүүлэх) • Хил хязгаар, зөвшөөрөл (consent), эерэг харилцааны талаар чиглүүлэх
Хүчирхийллийн эрсдэлийг бууруулах	<ul style="list-style-type: none"> • Бэлгийн, бие махбодын, сэтгэлзүйн хүчирхийллийн шинж тэмдгийг таньдаг байх • Мэдэгдэх, тайлагнах сувгийг мэддэг байх, сурагчид, тэдний эцэг эх, асран хамгаалагчдийг мэдээллээр хангах • Хүүхдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр “анхны алхам” авч хэрэгжүүлдэг байх • Хүүхэд бүрийн дуу хоолойг хүндэтгэх • Жендэрийн болон нийгэм эдийн засгийн ялгаваргүй үг, хэллэг хэрэглэх

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвар

Багш нар жендэрийн эрх тэгш байдлыг ойлгох төдийгүй хүүхдийн онцлогт тохирсон сургалтын аргыг ашиглах, сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн (бэлгийн болон бие махбод, сэтгэл зүйн) хэлбэр, шинж тэмдэгийг

таних, урьдчилан сэргийлэх чадвартай байх шаардлагатай. Багш нар хүүхдийн сурах орчны гол төлөөлөгчид бөгөөд тэдний хандлага, харилцаа нь сургуулийн соёл, сурагчдын сэтгэл зүй, аюулгүй байдалд хүчтэй нөлөө үзүүлдэг. Иймээс багш нарт дараах чиглэлээр **тусгайлсан сургалт** зайлшгүй шаардлагатай.

Хүснэгт 2. Багш нарт чиглэсэн тусгай сургалт, үйл ажиллагаа

4

<p>Жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголт</p>	<p>Жендэрийн эрх тэгш байдал, хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтын нөлөөлөл, тэдгээрийн боловсролын орчин дахь илрэл, үр дагаврыг танин ойлгох. Багш нар жендэрийн ялгаварлал, хэвшмэл ойлголтыг таних, боловсролын орчинд илрэх хэлбэрүүдийг ойлгож байж, тэгш, ялгаваргүй сургалтын орчин бүрдүүлж чадна⁵⁰.</p> <p>Жендэрийн хортой хэвшмэл ойлголтоос ангид жендэрийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр⁵¹ нь боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Энэ нь эрт жирэмслэх, гэрлэх явдлыг бууруулах, эмэгтэйчүүд болон бэлгийн цөөнхийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг арилгах үндэс болно.⁵² Боловсролын хөтөлбөрт жендэрийн тэгш байдлын талаарх хэлэлцүүлэг, энх тайван, хүний эрх, ардчилсан зарчим, үнэт зүйлсийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол, эрүүл мэнд, хүнсний хангамж, амьжиргаанд үзүүлэх нөлөө зэрэг нийгмийн олон асуудлын уялдаа холбоог хүлээн зөвшөөрөх агуулга багтах ёстой. Шүүмжлэлт сэтгэлгээ, соёл хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, нийгэм-сэтгэл зүйн сургалт, дижитал ур чадвар, уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол зэрэг XXI зууны ур чадварууд нь албан болон албан бус боловсролын сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг байх ёстой бөгөөд ингэхдээ охидод хүртээмжтэй, тэгш хамрагдах боломж олгох ёстой.</p>
<p>Хүүхдийн онцлогт тохирсон сургалтын арга зүй</p>	<p>Нас, хүйс, хөгжлийн онцлогт нийцсэн, оролцоог дэмжсэн, ялгаваргүй, эерэг арга барилыг хэрэглэх хэрэгтэй. Хүүхдийн нас, хүйс, хөгжлийн хэрэгцээг харгалзсан, ялгаваргүй, эерэг сургалтын аргыг хэрэглэх нь суралцах идэвх, хамрагдалтыг нэмэгдүүлж, оролцоог хангадаг⁵³.</p>
<p>Хүчирхийллийн хэлбэр, илрэх шинж тэмдгийг таних</p>	<p>Бэлгийн, бие махбодын, сэтгэлзүйн, үл хайхрах хэлбэрийн хүчирхийллийг ялгах, хүүхдийн өдөөгдөх дохиог таних, мэдэгдэх ёстой байгууллага, сувгийг мэддэг байх шаардлагатай. Сургуулийн орчин дахь бие махбод, сэтгэлзүйн, үл хайхрах, бэлгийн хүчирхийллийн анхны шинж тэмдгийг таньж, хүүхдэд тусламж үзүүлэх анхны алхам бол багш нар мэдээлэл, мэдлэгтэй байх явдал юм⁵⁴.</p>
<p>Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эерэг харилцаа төлөвшүүлэх арга зүй</p>	<p>Багш нар сурагчдад зөвшөөрөл (consent), хил хязгаар, бэлгийн цогч боловсрол, өөрийгөө хамгаалах талаар ойлголтыг насны онцлогт тохирсон, энгийн, аюулгүй аргаар хүргэх чадвартай байх ёстой. Сургуулийн түвшинд «аюулгүй орчин», «итгэлцэлд суурилсан харилцаа» бүрдүүлэхэд багшийн оролцоо чухал гэдгийг ойлгох хэрэгтэй⁵⁵.</p>

50 A Guide for Gender Equality in Teacher Education Policy and Practices, UNESCO, 2015

51 "Биний нийтлэг зорилго" бодлогын хураангуй, Хувирган өөрчлөх боловсрол, НҮБ 2023 <https://www.un.org/sites/un2.un.org/files/our-common-agenda-policy-brief-transforming-education-en.pdf>

52 EM2030-ийн мэдээлснээр 2030 он гэхэд ямар ч улс жендэрийн тэгш байдлыг хангахгүй. Жендэрийн тэгш байдлын ирээдүй хямралд орсон уу? ТХЗ Жендэрийн индексийн судалгааны дүгнэлт https://equalmeasures2030.org/wp-content/uploads/2024/09/EM2030_2024_SDG_Gender_Index_EN_digital.pdf

53 Technical Note on Gender-Responsive Pedagogy in Education, UNGEI & UNICEF, 2020

54 Global Guidance on Addressing School-Related Gender-Based Violence, UNESCO & UN Women, 2016

55 Comprehensive Sexuality Education – Guidelines for Curriculum Development, UNFPA, 2014

Сургуулийн дотоод журам, тайлагнах, мэдээлэх тогтолцооны талаарх мэдлэг	Хүчирхийллийн тохиолдолд хэрхэн хариу үзүүлэх, хүүхдийг дэмжих, хамгаалах ёстой журмыг мэдэх ба хэрэгжүүлэх буюу багш нар хүүхдийг хамгаалах, мэдээлэх ёстой холбогдох байгууллага, журам, арга замыг мэддэг байх нь чухал ⁵⁶
Туршлага солилцох, харилцан суралцах багшийн сүлжээ бий болгох	Багш нар бие биетэйгээ туршлага солилцох, хувийн хандлагаа эргэцүүлэх орчин байснаар жендэрийн мэдлэг, ойлголт илүү гүнзгий, бодитой болдог. Үүнийг бусад багш нар, сургуулийн удирдлага, зөвлөх, яамны жендэрийн мэргэжилтэн, салбарын жендэрийн шинжээч болон энэ чиглэлээр мэргэшсэн хүн, багш-эцэг, эх, асран хамгаалагчдын холбоо, жендэрийн эрх тэгш байдлын чиглэлээр ажилладаг ИНБ болон багш өөрөө эрэл хайгуул хийж жендэрийн талаарх мэдлэг ойлголтоо тогтмол эргэцүүлэх, шинэчлэх тогтолцоог бий болгох шаардлагатай ⁵⁷ .

Жендэрийн тэгш байдлын талаарх ойлголт, хандлагыг хөгжүүлэхэд багшийн бие даасан сурч хөгжих боломж төдийгүй хамтын хөгжлийн орчин маш чухал нөлөөтэй. Тиймээс дараах чиглэлүүдээр харилцан суралцах, мэдлэг хуваалцах багшийн сүлжээ бий болгох шаардлагатай:

- Багш бүр өөрийн жендэрийн талаарх мэдлэг, ойлголт, практикийг харьцуулах, эргэцүүлэх боломжийг олгох⁵⁸
- Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ялгаваргүй сургалтын арга зүйг хуваалцах⁵⁹
- Сургуулийн соёлыг өөрчлөхөд хамтын нөлөө үзүүлэх, багш нарын хооронд итгэлцэлтэй, суралцах хамтын ажиллагааг бий болгох⁶⁰ чиглэлээр байнгын сүлжээг бий болгох.



56 Minimum Standards for Child Protection in Humanitarian Action, UNICEF, 2020
 57 Promoting Gender equality in education, UNESCO, 2009
 58 Gender at the Centre Initiative: Whole-school Approach to Gender Equality, UNESCO & UNGEI 2022
 59 Teacher Training Manual on Gender Equality and Positive Discipline, Plan International, 2018
 60 Teachers as Agents of Change: Supporting Peer Collaboration for Gender Equality, OECD, 2021

4.5 СУРГУУЛИЙН ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ

PISA - 2022 Сурлагын амжилтын олон улсын үнэлгээ нь Монголын сурагчдын сурлагын амжилтад сургуулийн уур амьсгал, багшийн хандлага, аюулгүй орчин, эцэг эхийн оролцоо зэрэг хүчин зүйлс хүйсээр ялгаатай байдлаар нөлөөлж байгааг харуулсан. Иймээс сургуулийн менежментийг жендэрийн хариуцлагатай болгох нь боловсролын чанар, хүртээмж, үр дүнд шууд нөлөөлөх бодлогын тэргүүлэх чиглэл байх шаардлагатай байна.

4

1. Жендэрийн хувирган өөрчлөлт хийх бодлого, журам
 - a) Сургуулийн дүрэм, дотоод журамд жендэрийн ялгаварлал, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх заалтыг тодорхой тусгах,
 - b) Хүүхэд хамгааллын бодлого нь охид, хөвгүүд, транс болон ялгаатай хэрэгцээт сурагчдын хэрэгцээг бүрэн тусгах,
 - c) Сахилгын арга хэмжээ нь жендэрийн хэвшмэл ойлголт тусгаагүй, адилхан зөрчилд адил шийтгэл оногдуулдаг тогтолцоотой байх,
 - d) Сургуулийн аюулгүй ба дэмжлэгт байдлыг сайжруулах зорилгоор аюулгүй байдлын хяналт-шинжилгээг тогтмолжуулах
2. Удирдлагын түвшний чадавх бэхжүүлэх
 - a) Захирал, менежер, ЗАН-ийн ахлагч, залуу багш нарыг жендэрийн эрх тэгш байдал, сургалтын менежмент, сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сургалтад тогтмол хамруулах,
 - b) Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги боловсруулахдаа Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, PISA - 2022 үнэлгээний охид-хөвгүүдийн амжилтын зөрүү болон сургуулийн уур амьсгалын мэдээллийг ашиглах,
 - c) Сургууль дээрх хороо, баг, зөвлөлүүдийн бүрэлдэхүүнд жендэрийн тэнцвэртэй оролцоог хангах,
 - d) Удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээнд жендэрийн эрх тэгш байдлын талаар үзүүлэлтийг тусгах,
3. Жендэрийн хариуцлагатай хүний нөөцийн удирдлага
 - a) Багш, ажилтнуудыг жендэрийн хариуцлагатай арга зүй, ялгаварлалгүй харилцааны сургалтад тогтмол хамруулж хэвших,
 - b) Багшийн үнэлгээний шалгуурт суралцагчдыг хүйсээр ялгалгүй оролцуулах, хөвгүүдийн суралцах идэвхийг дэмжих, транс болон ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад онцгойлон анхаарах шалгуур оруулах,
 - c) Ажлын байрны аливаа дарамт, жендэрийн ялгаварлалын талаар багш, ажилтнууд гомдол гаргах аюулгүй, нууцаар мэдээлэх тогтолцоог цогц байдлаар бий болгох, тогтмол ажиллуулах,
4. Сургуулийн орчныг жендэрийн хувирган өөрчлөх хандлага, арга зүйгээр цогцоор нь шинэчлэх

- a) Ариун цэврийн өрөө, дотуур байр, амралтын хэсэг зэрэг орчныг охид, хөвгүүд, транс болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх. Ялангуяа жирэмсэн охидод зориулсан өрөө, эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлэх,
- b) Охидын сарын тэмдгийн үеийн онцгой хэрэгцээг хангах дотоод зохицуулалттай байх,
- c) Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоо ба мэдээлэх сувгийг ажиллуулах
- d) PISA - 2022 "сургуулын уур амьсгалын индекс"-ийг сайжруулах зорилгоор анги танхимд эрүүл, хүндлэл бүхий харилцааны соёлыг нэвтрүүлэх чиглэлээр хүчин чармайлт гаргах

4



4.6 ЖЕНДЭРИЙН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ БОЛОВСРОЛЫН ТӨСӨВ

4

Жендэрийн хувирган өөрчлөлт хийх боловсролд төсөв хамгийн чухал. Илүү тэгш, үр ашигтай санхүүжилт нь хүний эрхийг хангах, хамгаалах, хэрэгжүүлэхэд урт хугацааны, тогтвортой санхүүжилт шаардлагатай. Дотоодын санхүүжилтийн зөрүүг арилгахын тулд ДНБ-д ногдох хэмжээг нэмэгдүүлэх нь чухал бөгөөд ДНБ-ний наад зах нь 4-6% болон/эсвэл улсын төсвийн наад зах нь 15-20%-ийг боловсролын салбарт үр дүнтэйгээр хуваарилах шаардлагатай.

Боловсролын санхүүжилтийн дутагдлыг нөхөхийн тулд олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, хөгжиж буй орнуудын боловсролд хуваарилах санхүүжилтэд нөлөөлж буй гадаад өрийг бууруулах шаардлагатай. Хөгжиж буй орнуудад зориулсан албан ёсны хөгжлийн тусламжийг (ODA) нийт үндэсний орлогын 0.7% -д хүргэх талаарх бүх амлалтуудын хэрэгжилтийг хурдасгах нь чухал юм. Ингэснээр боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүгийн бэрхшээлээс үл хамааран чанартай боловсролыг хүн бүрт хүргэх боломжтой болно.

- **Төсөв бол бодлогын хэрэгсэл юм.** Улс төр, нийгэм, эдийн засгийн чиглэл, тэргүүлэх зорилтыг илэрхийлдэг төсвийг жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих чиглэлд ашиглах нь чухал.
- **Жендэрийн ялгаатай бүлгүүдийн эрхийг хамгаална.** ЖХТ нь олон талт, ялгаатай бүлгүүдийн эсрэг нийгэм, эдийн засгийн ялгаварлал, гадуурхалтыг илрүүлж, шийдвэрлэх гол арга зам юм.
- **Тэгш байдал ба шударга ёсыг бэхжүүлэхэд төсөв тусална.** Төсвийн нөөцийн зарцуулалт хэнд, хэрхэн хүрч байгааг тодорхой болгох замаар бодлого, төсвийн шийдвэрийг илүү шударга болгоно.
- **Ядуурлыг бууруулахад үр нөлөөтэй.** Эмэгтэйчүүд, үндэстний цөөнх, бэлгийн цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд ядуурлын нөлөөнд илүү өртөмтгий бөгөөд тэдний хэрэгцээнд нийцсэн бодлого, төсвийн хуваарилалт ядуурлын бууралтад нөлөөлнө.
- **Бодлогын хэрэгжилтэд хяналт тавих боломж.** Бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө мөнгө, дэмжлэг хүрч байгаа эсэхийг хянахад ЖХТ тусалдаг.
- **Сайн засаглалын чухал бүрэлдэхүүн.** Ил тод, хариуцлагатай, үр дүнтэй төрийн үйлчилгээ үзүүлэхэд ЖХТ чухал нөлөөтэй.
- **Эдийн засгийн үр ашигтай.** Эмэгтэйчүүд, үндэстний цөөнх, бэлгийн цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн оролцоо, хүний хөгжлийг дэмжих нь нийт эдийн засагт өгөөжтэй байдаг.

ЖЕНДЭРИЙН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨӨХ БОЛОВСРОЛЫН ТӨСВИЙН БОДЛОГОД ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ АЛХАМУУД

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөөний 3.3.2-т “Орон нутгийн түвшин (аймаг, сум, нийслэл, дүүргийн онцлогт нийцүүлэн)-д ЖХТ-ийг хэрэгжүүлэх удирдамж боловсруулж, нэвтрүүлнэ.” 3.4.9-т “Төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тодорхой чиг үүргийг ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлэх, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах талаар нийтлэг удирдамж боловсруулж, салбар зөвлөл, салбар хорооны хяналттайгаар хэрэгжүүлнэ.” гэж заасан.

4

Жендэрийн хариу үйлдэл үзүүлэх төсөвлөлтийг хэрэгжүүлэхийн тулд:

- **Яамны бодлого төлөвлөлтийн нэгжид ЖХТ-ийн байнгын чиг үүргийг бий болгох** (Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод оруулах) Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хариуцах шийдвэр гаргагчийг томилох
- **Яамны төлөвлөлтийн үйл явцад ЖХТ-ийн арга хэрэгслийг нэгтгэх, чадавхыг бэхжүүлэх** Жендэрийн дүн шинжилгээ болон жендэрийн төлөвлөлт болон төсөвлөлтийг боловсруулах Жендэрийн статистик болон захиргааны мэдээллийг сайжруулах шаардлагатай. Ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж тогтвортой байдлыг хангах шаардлагатай.
- **Жендэрийн мэдрэмжтэй гүйцэтгэлийн тайлан болон ил тод байдал** Оролцогч талуудын жендэрийн мэдрэмжтэй үйл ажиллагаа, тэдгээрийн үр дүнгийн талаар мэдээллийн санг тогтмол бүрдүүлж, хянах шаардлагатай. Хэрэгжүүлсэн бодлого болон төсөвтэй холбоотой тайлагналын бүх шаардлага, журмыг дунд хугацааны болон жилийн түвшинд тогтмол хянан үзэж, жендэрийн хүрсэн үр дүнгийн талаарх дутуу мэдээллийг нөхөн бүрдүүлэх шаардлагатай. Жендэрийн хүрсэн үр дүнгийн талаарх бүх яамны нэгжүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн ЖХТ-ийн тайланг танилцуулж, олон нийтэд нээлттэй байлгах шаардлагатай ба уг тайланд жил бүр төлөвлөсөн ажил болон хүрсэн үр дүнгийн талаарх мэдээллийг багтаах.

Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг дэмжих төсөв

Хүүхдийн боловсролд хамрагдалт нь хүйсийн болон бүс нутгийн ялгаатай байдлаар илэрдэг тул дараах чиглэлд төсөв шаардлагатай:

- Сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авахад чиглэсэн хөтөлбөрт төсөв тусгах,
- Хөвгүүдийн завсардалтын гол шалтгаан болох мал аж ахуй, хөдөлмөр эрхлэлт, улирлын шилжилт хөдөлгөөнийг бууруулах хөтөлбөрүүдэд төсөв тусгахад анхаарах,
- Охидын өсвөр насны жирэмслэлтээс үүдэлтэй хичээл таслалт, сургууль завсардалтын асуудлыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа,

нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө, эргэн суралцахад чиглэсэн хөтөлбөрт төсөв тусгах,

- Алслагдсан бүсийн хүүхдүүдэд зориулсан хоол, тээвэр, дотуур байрны санхүүжилтэд хангалттай төсөв тусгах,
- Дотуур байр болон сургуульд бие даан хөгжих танхим хүртээмжтэй байж, тогтмол ажиллуулах,
- Хичээлийн хоцрогдлыг нөхөх багш, нийгмийн ажилтны орон тоо нэмэгдүүлэх, тогтмол чадавхжуулах,

Цалин хөлс болон санхүүгийн эрх тэгш байдлыг хангах

Төсөвлөлтийн түвшинд багш, ажилтнуудын цалин хөлсний тэгш байдлыг хангах нь жендэрийн эрх тэгш байдлын үндсэн шаардлага:

- Эрэгтэй, эмэгтэй багш нарын хоорондын цалин хөлсний ялгааг тогтмол хянах
- Хөдөө орон нутаг, алслагдсан сумдын багш нарт өгөх нэмэгдлийг хүртээмжтэй, ялгаваргүй олгох
- Тэнцвэртэй төлөөллийг дэмжих зорилгоор удирдах албан тушаалд ажиллах багш нарт удирдлага, манлайллын сургалтын санхүүжилт төсөвлөх, хүйсийн ялгааг анхаарах,
- Жендэрийн ялгаварлалтай цалингийн зөрүү илэрсэн тохиолдолд засварлах төсвийг тусгах



4.7 ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛ

Жендэрийн хариу үйлдэл үзүүлдэг, хүүхдийн сайн сайхан байдалд ээлтэй суралцахуйн орчныг бий болгоход орон нутаг, эцэг эх, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа чухал. Ялангуяа жендэрийн тэгш байдлын талаар мэдээллээр хангах үйл ажиллагааг сургуулийн удирдлагууд манлайлан ажиллах шаардлагатай.

Эцэг эх, асран хамгаалагч, сурагч, олон нийтийн оролцоог сургуулийн бодлогод тусгах: Сургуулийн бодлого, хөтөлбөрийг бодит хэрэгцээтэй уялдуулахын тулд сурагч, эцэг эх, олон нийтийн дуу хоолойг тусгах нь чухал. Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийн хандлага, зан үйлд гүн нөлөөтэй тул тэднийг шийдвэр гаргах, бодлого боловсруулах түвшинд оролцуулбал бодлого илүү амьдралтай, үр дүнтэй болдог⁶¹.

Жендэрийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх аян зохион байгуулах: Сургуулийн түвшинд хийх өөрчлөлтүүд зөвхөн дотооддоо биш, өргөн хүрээнд нийгмийн хандлага, ойлголтыг өөрчлөх аянтай хавсарч байж тогтвортой үр дүнд хүрдэг. Орон нутгийн телевиз, радио, сошиал медиа, эцэг эхийн хурал, олон нийтийн арга хэмжээ зэрэг сувгаар дамжуулан жендэрийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, сургуулийн орчны өөрчлөлтийг нийгмийн дэмжлэгтэй болгох хэрэгтэй⁶².

Суралцагчдын оролцоо, дуу хоолойг дэмжих клуб, санаачилгыг байгуулах: Суралцагчид өөрсдийн дуу хоолойг илэрхийлэх, бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцох орон зайтай болсноор тэд өөрийгөө үнэлэх, бусдын эрхийг хүндэтгэх хандлагатай, бие даасан иргэн болон төлөвшдөг. Хичээлийн бус цагт клуб, санаачилга, манлайллын сургалт зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан жендэрээс үл хамааран суралцагчдын тэгш оролцоог дэмжих нь тэдний нийгмийн үр чадварыг хөгжүүлдэг⁶³.



61 Engaging parents in education: Lessons from international experiences, UNESCO, 2017; Parent and Community Engagement Framework in Schools, UNICEF, 2018

62 Leave No Girl Behind: Mobilizing Communities for Gender Equality in Education, UNGEI, 2020

63 Adolescent Participation and Civic Engagement, UNICEF, 2017



4.8 БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ЖЕНДЭРИЙН ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛДЭГ БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Баримт мэдээлэл цуглуулах, хяналт тавих: Маргиналчлагдсан бүлгүүд, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй, нон-байнари, бэлгийн цөөнх, хүйсийн цөөнх, үндэстний цөөнх, шашны цөөнх зэрэг олон давхаргад огтолцдог хүмүүсийн боловсролын хүртээмжийн асуудлыг шийдэхэд бодлого чиглэх ёстой боловч эдгээр бүлгүүдийн талаарх баримт мэдээлэл дутмаг байна. Иймээс бүх оролцогч талд хүртээмж бүхий чанартай, цаг үеэ олсон, нарийвчилсан мэдээлэл цуглуулах тогтолцоог бий болгох шаардлагатай. Ингэснээр ТХЗ-4 болон үндэсний боловсролын бодлогын хэрэгжилтийг иж бүрэн шинжлэх, үнэлэх, хяналт тавих боломж бүрдэнэ. Залуучуудын, боловсролын, эмэгтэйчүүдийн эрхийн зэрэг иргэний нийгмийн байгууллагуудын гаргасан судалгаа, үйл ажиллагааны тайлан иргэдийн амьдралд тулгарч буй бодит асуудлыг тусгадаг тул анхаарч, ач холбогдол өгч, дэмжих шаардлагатай. Түүнчлэн иргэний нийгмийн болон хүний эрхийн байгууллагуудын мэдээллийг агуулсан бүс нутгийн мэдээллийн сан байгуулж, мэдээллийн зөрүүг багасгахад ашиглах нь зүйтэй.

Жендэрийн ялгаатай хэрэгцээтэй бүлгүүдийн мэдээлэл цуглуулах ба шинжлэх⁶⁴

- Бүх хүйсийн сурагчдын элсэлт, хичээл таслалт, сурлагын амжилт, сургуулиас гарах, завсардах зэрэг үндсэн өгөгдлийг тогтмол давтамжтайгаар, системтэйгээр цуглуулна.
- Бүх өгөгдөлбодлогын дүн шинжилгээ, төлөвлөлт, шийдвэр гаргалтад ашиглана.
- Хандлага, туршлагын өөрчлөлтийг чанарын болон тоон судалгааны аргаар тогтооно. (сэтгэл зүйн судалгаа, фокус бүлгийн ярилцлага, анкет гэх мэт)

64 "Gender-Responsive Indicators for Education Sector Monitoring" UNESCO, 2010

Мэдээлэл цуглуулалт ба шинжилгээ

- Бодлогын хэрэгжилтийн эхлэл, дунд, төгсгөл үе шат бүрд шат дараалсан мэдээллүүдийг цуглуулна.
- Оролцогч талуудын хамт дүн шинжилгээ хийх боломжтой эсэхийг үнэлнэ.
- Цуглуулсан мэдээллийг бодлого, төсвийн шийдвэрт шингээж чаддаг байх шаардлагатай.

4

Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт

Үзүүлэлт	Жендэрийн нарийвчилсан хэлбэрээр
Элсэлтийн түвшин	Охид, хөвгүүдийн сургуульд элсэн орсон тооны харьцаа бүс нутаг, нас, нийгэм эдийн засгийн статусаар нарийвчилсан байх
Завсардалтын шалтгаан	Шалтгааныг нь хүйсээр, насаар ангилсан үнэлгээтэй байх
Төгсөлтийн хувь	Ерөнхий боловсролын сургууль төгсөж буй сурагчдыг хүйс, байршил, нийгэм эдийн засгийн статусаар ангилсан байх,
Сургуулийн удирдлагын багийн гишүүдийн хүйсийн харьцаа	Эмэгтэй захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, ахлах багш нарын нийт багш нарын дунд эзлэх хувь

- Үнэлгээний хуудас нь жендэрийн ялгаатай байдлын талаарх үндсэн мэдээллүүдийг агуулсан байна.
- Төсөл/ хөтөлбөр/ үйл ажиллагаа нь жендэрийн тэгш байдлын хүлээгдэж буй үр дүн, холбогдох шалгуур үзүүлэлтийг багтаах ёстой. Ингэснээр хэрэгжүүлэгч болон оролцогч талууд төсөл/ хөтөлбөрийн үр дүнд хүний амьдралын мөчлөг, үе шат бүрт үнэлгээ хийх боломжтой.
- Жендэрийн ялгаатай бүлгүүдийн төлөөлөл мэдээлэл боловсруулахаас эхлэн бүхий л үе шатанд эрх тэгш оролцоотой байх.

Оролцоонд суурилсан үнэлгээ⁶⁵

- Сурагчид, багш, асран хамгаалагчдын сэтгэл ханамж, үнэлэмжид суурилсан үнэлгээ
- Үр шим хүртэгчдийн санал, оролцоог төлөвлөлтөөс үнэлгээний шат хүртэл бүхий л үед хамруулах

65 Guidance for Developing Gender-Responsive Education Sector Plans, GPE & UNGEI, 2017

Сайн туршлагыг түгээх⁶⁶

- Жендэрийн хариу үзүүлж буй сайн туршлагыг тогтмол баримтжуулах, тайлагнах, хуваалцах, түгээн дэлгэрүүлэх тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай.
- Үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд тохиромжтой жишиг практик бий болгох шаардлагатай.

4


Жендэрийн хариу үйлдэл үзүүлдэг төсөвлөлтийн хүрээнд боловсролын салбарт хийх гол алхмууд

- Жендэрийн ялгаатай бүлгүүдийн ангилал бүхий боловсролын статистик цуглуулах, дүн шинжилгээ хийх шаардлагатай.
- Төсвийн хэрэгжилтэд жендэрийн нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагатай.

Жишээ нь: Математик, техник технологид зориулсан төсвийн санхүүжилт нь охидын оролцоог нэмэгдүүлэхэд ямар үр дүн өгч байгаа вэ?

Төсвийн хяналт-шинжилгээ, үнэлгээ⁶⁷

- Жендэрийн шалгуур үзүүлэлт бүхий төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах хэрэгтэй.
- Охид, хөвгүүдийн суралцах орчны ялгааг илрүүлж, түүнийг арилгах зардлыг тусгах, шаардагдах урсгал зардлыг тооцох хэрэгтэй.



66 UNESCO GEM Report, Gender Report – A New Generation: 25 Years of Efforts for Gender Equality in Education, 2020

67 Guidance for Gender-Responsive Education Sector Planning, UNGEI & GPE, 2021

4.9 САЛБАР ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Боловсролын салбарын манлайлал дор хувирган өөрчлөх жендэрийн боловсрол нь дараах 3 түвшинд хэрэгжих боломжтой. Үүнд:

Үндэсний түвшинд: Салбар хоорондын хууль, бодлогын уялдааг бий болгох зорилгоор боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, хууль зүй, дотоод хэрэг, хүүхэд, гэр бүл хариуцсан яамд хооронд хамтын ажиллагаа, бодлогын уялдааг хангах,

Дунд түвшин: Үүнд сургуулийн захирал, дүүрэг/аймгийн боловсролын газар, хэлтэс, Багш нарын мэргэжлийн холбоо, Үйлдвэрчний эвлэл, сургуулийн зөвлөлүүд зэрэг үндэсний болон сургуулийн түвшний хооронд орших бүтэц багтдаг. Энэ түвшинд бодлогын уялдаа, хамтын ажиллагаа нь амьдрал дээр хэрхэн хэрэгжиж буйг зохицуулах чухал гүүр болно.

Сургуулийн түвшин: Бодлогыг хэрэгжүүлэх шууд орчин. Багш нар, сургуулийн удирдлагын баг, ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчид, сурагчид хамтран ажиллах хэрэгтэй.

Зураг 3. Боловсролын салбарын манлайлал дор СХЖСХ-ийн хариу арга хэмжээнд оролцдог олон талт түншлэл⁶⁸



Боловсрол, эрүүл мэнд, хууль эрх зүй болон залуучуудын асуудал хариуцсан салбарууд хамтран ажиллах тогтолцоо бүрдүүлэх⁶⁹: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудал нь зөвхөн боловсролын салбарын асуудал биш. Охид, хөвгүүд, транс суралцагчдын эрх, аюулгүй байдал, эрүүл мэнд, хууль зүйн хамгаалал зэрэг олон талт ялгаатай хэрэгцээтэй нягт уялддаг. Иймд эрүүл мэндийн үйлчилгээ,

68 СХЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах дэлхийн удирдамж, Боловсрол эвсэл, 2025 он

69 A Whole-School Approach to Prevent School-Related Gender-Based Violence, UNGEI & UNICEF, 2020

хууль зүйн зөвлөгөө, хүүхэд хамгааллын тогтолцооны уялдааг сайжруулах нь хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш оролцоог хангахад онцгой чухал.

Бүх нийтийн цахим хүртээмж болон ШИМТ: Дэлхийн дижитал гэрээ⁷⁰ хэрэгжүүлэхийн тулд юун түүвэнд охид болон эмзэг бүлгүүдийн дижитал ялгааг арилгах учиртай. Үүний тулд хүртээмжит, хямд үнэ бүхий дэд бүтцийг бий болгож, аюулгүй байдлаа ханган эрүүл мэнд, хөгжилдөө ашиглах дижитал ур чадвар, чадавхийг олгох чухал. Дэлхийн, бүс нутгийн, үндэсний түвшинд аюулгүй, дижитал тэгш хүртээмжийг хангахын тулд хүчирхэг засаглал, зохицуулалтын хүрээ шаардлагатай. “Бүх нийтийн ШИМТ” нь бодлогын түвшинд дэмжигдэж байгаа боловч жендэрийн хэвшмэл ойлголт, саад бэрхшээлийг арилгах, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (МБТС), дадлагажих сургалт, санхүүгийн болон дижитал бичиг үсэгт тайлагдах боловсролыг өргөн хүрээнд олгох шаардлагатай. Үүнийг мэргэжлийн сургалтууд, албан бус боловсролыг албан боловсролын тогтолцоотой хослуулан хэрэгжүүлэх нь зүйтэй.

Эрхэд суурилсан, насан туршийн суралцахуйг хангасан насанд хүрэгчдийн боловсролыг дэмжих: Ихэнх боловсролын тогтолцоо нь зөвхөн хүүхдүүдэд зориулсан сургалтад төвлөрдөг ба залуучууд болон насанд хүрэгчдийн сурч боловсрох эрхийг орхигдуулдаг. Марракешийн үйл ажиллагааны хүрээнд (MFA)⁷¹ заасан үүргийн дагуу Насанд хүрэгчдийн боловсрол (НХБ)-ыг дэмжих, ТХЗ 4-т тусгагдсан хүн бүрийн насан туршийн суралцахуйг (НТС) хангах шаардлагатай. Жендэрийн хувирган өөрчлөх насанд хүрэгчдийн боловсрол нь эрүүл мэнд, хамгаалал, хуулийн салбарын оролцогчдыг нэгтгэсэн цогц, талуудын оролцоог хангасан, үе хоорондын байх ёстой. Үүнээс гадна ялгаварлан гадуурхлаас ангид, жендэрийн хариу үйлдэл үзүүлдэг сургалтын хөтөлбөр, сурах бичиг зэрэг сургалтын материалыг боловсруулж, шинэ тутам хөгжиж буй сургалтын чиглэлүүдийг хамруулах нь чухал. Эдгээр нь НТБ-г санхүүжүүлэх, багш нарыг сургах, уян хатан суралцах боломжийг дэмжих, залуучууд болон насанд хүрэгчдэд НТБ болон НТС-н боломжийн талаарх мэдлэг олгохыг шаардана. Мөн маргинал бүлгүүдийг оролцуулж, тэднийг ажил, амьдралын сорилтыг даван туулах ур чадварт сургах ёстой. Тэдэнд хөдөлмөрийн зах зээлд оролцох боломжийг бий болгож, дижитал болон ногоон ур чадвар эзэмших, бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зэргээр хөдөлмөрийн зах зээлд оролцох боломжийг олгож, хөдөлмөрийн эрхлэлтийн зөрүүг багасгахад хувь нэмэр оруулна.

Боловсролыг бүх нийтийн оролцоотойгоор хөгжүүлэх: Засгийн газрууд хүн бүрийн боловсрол эзэмших эрхийг хангах үүрэгтэй бөгөөд энэ зорилгоор бүх түвшний боловсролын өөрчлөлтөд хариуцлагатай, ил тод механизм шаардлагатай. Иймд суралцагч, эцэг эх, гэр бүл, багш, сургуулийн удирдлага, орон нутгийн удирдлага, улс төрч, ахмадууд, залуус, хөдөлмөрийн болон иргэний нийгмийн байгууллагууд нь боловсролын өөрчлөлтөд оролцож, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн болон нийгмийн хортой хэм хэмжээний нөлөөг арилгахад оролцох боломжтой байх ёстой.

70 Ирээдүйн төлөөх дээд хэмжээний уулзалт, Дэлхийн дижитал гэрээ <https://www.un.org/en/summit-of-the-future/global-digital-compact>

71 2022 онд Насанд хүрэгчдийн боловсролын VII бага хуралд ЮНЕСКО-ын 140 гишүүн улсууд оролцож, “Марракешийн үйл ажиллагааны хүрээ”-г баталсан. Үүгээр боловсрол, тэр дундаа насанд хүрэгчдийн боловсрол нь хүний үндсэн эрх гэдгийг хүлээн зөвшөөрч, насанд хүрэгчдийн боловсролын төсвийг нэмэх, одоогийн төсвийг бууруулахаас сэргийлэхийг уриалжээ.

Жендэрийн хариу үйлдэл үзүүлдэг статистик, судалгаанд тулгуурласан бодлого боловсруулах: Бодлого боловсруулагчид охид, хөвгүүд, транс суралцагчдын ялгаатай нөхцөл байдал, хэрэгцээг ойлгож, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахын тулд нас, хүйс, газарзүйн байршил, нийгэм эдийн засгийн статус, хөгжлийн онцлог зэргээр ангилсан чанартай дата шаардлагатай. Жендэрийн хариу үйлдэл үзүүлдэг дата нь сургалтын хоцрогдол, дотуур байрны хүртээмж, жендэрт суурилсан хүчирхийлэл, сургууль завсардалт зэрэг асуудлыг илрүүлж, тэгш боломжийг бий болгох түлхүүр болдог.

Төрийн бус болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах⁷²:

Боловсролын салбар дангаар шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй. Харин төрийн бус байгууллагууд болон олон улсын байгууллагууд бодлого боловсруулах, багш бэлтгэх, арга зүй хөгжүүлэх, хэрэгжилт хянах зэрэг чиглэлээр дэмжлэг үзүүлэх боломжийг ашиглах хэрэгтэй. Хамтын ажиллагаа нь инноваци, туршлага хуваалцах, зөвлөмж боловсруулахад онцгой ач холбогдолтой. Ингэснээр салбарын чадавх бэхжиж, үр дүн илүү баталгаатай болно. Мөн "Жендэрийн хувирган өөрчлөлт хийх боловсрол"-ыг бодит болгоход Үйлдвэрчний эвлэл, багшийн мэргэжлийн холбоод манлайлал үзүүлэх хэрэгтэй. 2014 онд болсон Олон улсын Боловсрол (Education International) байгууллагын Эмэгтэйчүүдийн Дэлхийн Бага Хурал дээр СХЖСХ-ийн асуудал үндсэн сэдвүүдийн нэг байв. Тус хурлаас дараах гол зөвлөмжүүд гарсан. Үүнд:

Мэргэжлийн ёс зүйн талаарх Олон улсын боловсрол (Education International) байгууллагын Тунхаглалыг шинэчлэн боловсруулж, сургуулийн орчин дахь бүтцийн болон бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой заалтуудыг тодорхой тусгах; энэхүү тунхаглалыг бүх багш нарт хүртээмжтэй байдлаар таниулах, түгээх,

Олон улсын боловсрол байгууллагын гишүүд⁷³ улс орныхоо сургалтын хөтөлбөрт жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг тусгахын төлөө манлайлан ажиллах,

Бүс нутгуудад СХЖСХ-ийн тархалт, хэлбэрүүд, мөн үүний эсрэг багш нарын гүйцэтгэх үүргийн талаар судалгаа хийх; энэхүү судалгаанд улс орнуудын боловсролын Үйлдвэрчний эвлэлүүдийн СХЖСХ-ийн эсрэг хэрэгжүүлж буй шилдэг туршлагаудыг багтаах ба охид, хөвгүүдийг сургууль завсардахгүй байхад чиглэсэн орон нутгийн болон хамтын нийгэмлэгүүдийн шилдэг санаачлагуудыг түгээн дэлгэрүүлэх.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

72 Strengthening Partnerships with Civil Society for Gender-Responsive Education, GPE, Global Partnership for Education, 2021

73 Монгол улсад МБШУҮЭ-ийн холбоо нь гишүүнчлэлтэй байдаг.



БИДНИЙ ХУВИРГАН ӨӨРЧЛӨХ СТРАТЕГИ

Боловсролын хүрээнд, боловсролоор дамжуулан жендэрийн эрх тэгш байдалд хүрэх нь бидний бодлогын нөлөөллийн тэргүүлэх чиглэл юм. Боловсролын салбар нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний болон олон улсын бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө бүхий институтацийн нэг бөгөөд жендэрийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтыг бууруулах, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог төлөвшүүлэхэд стратегийн ач холбогдол бүхий орон зай юм.

Зураг 4. Жендэрийн тэгш байдлыг боловсролд хэрэгжүүлэх тогтолцооны өөрчлөлт хийх зураглал⁷⁴



Боловсролын хүртээмж (access to): Бүх хүнд эрх тэгш хүртээмжийг бий болгохыг дэмжих нь жендэрийн болон бусад шинж чанарууд нь бодит нөхцөл байдалтай нь хослосон охид, хөвгүүдийн боловсрол эзэмших эрхийг үгүйсгэхэд хүргэж буй боловсролын тэгш бус байдлыг арилгахыг ойлгоно. Бодит өөрчлөлтийг хурдасгахын тулд боловсролын тэгш хүртээмжийн эрэлт болон нийлүүлэлтийн талыг системийн түвшинд шийдвэрлэх шаардлагатай. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй, өсвөр насны охид боловсрол эзэмшихийн тулд орон нутгийн буюу гэртээ ойр, тэгш хүртээмжтэй сургуулийн байгууламж, түгээмэл суралцахуйн загварт мэргэшсэн багш нар, багш бэлтгэх сургалтын хөтөлбөр нь тэгш хамруулах тогтолцооны нэг хэсэг байх гээд шаардлагууд үүснэ. Мөн гэр бүл нь тухайн охинд боловсрол эзэмшүүлэх хүсэл эрмэлзлэл нь жендэрийн болон хөгжлийн бэрхшээлийн талаар тогтсон хэм хэмжээг сөрөх, сургууль руу явах зайг туулахад аюулгүй байдлыг хангах чадавхтай, чадвартай байх зэрэг асуудлыг шийдвэрлэх замаар тухайн хүүхдийн сурч боловсрох эрхийг шийдвэрлэнэ гэсэн үг.

74 <https://www.globalpartnership.org/content/going-further-together-partnership-approach-gender-equality>

Боловсролын хүрээнд (within): Хүүхдүүд сургуульд элсэхэд тулгардаг жендэрийн саад бэрхшээлийг даван туулдаг ч гэсэн суралцахуйн туршлага нь жендэрээс гүнзгий хамааралтай хэвээр байна. Тогтолцооны түвшний шинэчлэл бол багш бэлтгэж буй сургалтад жендэрийн мэдрэмжтэй сурган хүмүүжүүлэх арга зүйг багтаасан бодлого, практикийг нэвтрүүлэх чухал. Энэ нь багшлах болон суралцах үйл явцад охид хөвгүүдэд суралцахуйн ялгаатай хэрэгцээнд анхаарахыг дэмжинэ. Мөн жендэрийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтыг арилгахын тулд сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэх боломжтой. Эдгээр жендэрийн хувирган өөрчлөлт хийх боловсролын бодлого, практик нь охидыг уламжлал ёсоор эрэгтэй гэж үздэг хичээл, мэргэжилд хамрагдахаас татгалзахгүй байх, хөвгүүдийг эрэгтэйлэг байдлын нөхцөл байдалд тохирсон хэм хэмжээтэй нийцэхгүй боломжуудыг судлахаас татгалзахгүй байх явдалд тусалдаг. Боловсролын хүрээнд жендэрийн тэгш байдлын энэхүү хэмжээс нь үе тэнгийн дээрэлхэлтээс эхлээд бие махбодын болон бэлгийн дарамт хүртэлх сургуультай холбоотой олон хэлбэрийн хүчирхийллийн эсрэг зохих хариу арга хэмжээ авах бодлого, практикт онцгой ач холбогдолтой.

Боловсролоор дамжуулан (through): Сургууль бол жендэрээс үл хамааран хүмүүст хөгжих боломжийг олгох орчныг загварчлах боломжтой газар. Боловсролоор дамжуулан жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг шийдвэрлэснээр өсвөр үе, залуусыг шүүмжлэлт сэтгэлгээний чухал ур чадваруудад суралцуулж, тэдний эрхийг ойлгож, өөрчлөлтийн төлөөлөгч болоход нь дэмжлэг үзүүлэх боломжтой. Жишээ нь: эмэгтэйчүүдийг сургуулийн удирдах албан тушаалд дэвшүүлэх, сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгохдоо жендэрээс үл хамаарах зэрэг. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрүүл харилцаа, эрх мэдэл, хүндэтгэлийн талаарх хэлэлцүүлэг нь жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгааныг шийдвэрлэх, эрт болон хүсээгүй жирэмслэлтээс зайлсхийх, ХДХВ/ДОХ-ын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг нэмэгдүүлэхэд тусалдаг болохыг баримтууд харуулдаг. Охид, хөвгүүд бүр өөрсдийн боломжоо ухамсарлахад саад болж буй нийгэм дэх жендэрийн дүр-үүргийн эргэн тойрон дахь хор хөнөөлтэй хэм хэмжээ, хүлээлтийг өөрчлөхөд хэрхэн оролцохоо суралцаж чадна.


Тогтолцооны өөрчлөлтөд оролцож буй нийгэм, хамт олон, гэр бүлүүд гээд оролцогчдын жендэрийн тэгш байдлын төлөөх боломжит бүх чиглэлийг хамарч буй нийгмийн хэм хэмжээний өөрчлөлтийн нөлөөг ч бас мартаж болохгүй. Нийгмийн хэм хэмжээ гэдэг нь ихэнх хүмүүсийн хүлээн зөвшөөрч, дагаж мөрддөг далд болон албан бус дүрмүүд. Эдгээр нь бидний итгэл үнэмшил, эдийн засгийн нөхцөл байдал, заримдаа тэдгээрийг дагаж мөрдөх эсвэл дагахгүй байхын тулд бидний хүлээж болох шагнал, шийтгэлээс хамаардаг. Хэм хэмжээ нь албан болон албан бус талбаруудад шингэсэн байдаг бөгөөд нийгмийн харилцааны замаар бий болж, хуулбарлагддаг. Эдгээр нь бидний хангалттай олонх нь өөр аргаар сонгох эсвэл өөр арга хэмжээ авахад албадсан үед л өөрчлөгдөж, шинэ хэм хэмжээг бий болгодог. Жендэрийн хэм хэмжээ нь нийгмийн хэм хэмжээний дэд хэсэг юм. Эдгээр нь бид эсвэл бусад хүмүүс хүйсээ хэрхэн тодорхойлж байгаагаас шалтгаалан бид хэрхэн биеэ авч явах ёстойг тодорхойлдог. Жендэрийн хэм хэмжээ нь жендэрийн тэгш бус харилцааг тусгаж, бэхжүүлдэг бөгөөд энэ нь ихэвчлэн эмэгтэйчүүд, охидод төдийгүй хүйсийн нийтлэг хэм хэмжээг дагаж мөрддөггүй эрчүүд, хөвгүүд, хүйсийн олон янзын ижил төстэй хүмүүст ч бас сөрөг нөлөө үзүүлдэг. Жендэрийн хэм хэмжээ нь нас, арьс өнгө, үндэс угсаа, нийгмийн

давхарга, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг гэх мэт бусад хүчин зүйлстэй холбоотой бусад хэм хэмжээ, тэгш бус байдалтай огтлолцдог.

Боловсрол дахь жендэрийн тэгш байдал нь охид, хөвгүүдийн боловсролын хамрагдалт, суралцах үйл явц, эдлэх боломжийн хүртээмжтэй байдал, мөн агуулга, боловсрол олгохдоо (суралцах үйл явцад хэрэглэгдэх нөөц, орчин, заах арга, дэмжлэгийн систем) эрх тэгш байх, ингэснээр суралцагчид сургуулиа төгсөхдөө илүү эрх тэгш нийгэм байгуулахад хувь нэмрээ оруулна гэсэн үг.

Иймд боловсролын бүх түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, бодлого төлөвлөлт, хөтөлбөр, агуулга, сургалтын арга зүй, орчныг системтэйгээр жендэрийн хариу үйлдэл үзүүлдэг болгох шаардлагатай. Мөн багш, ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, судалгаа-шинжилгээ, нотолгоонд суурилсан бодлого хэрэгжүүлэх, мониторинг үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох нь жендэрийн тэгш байдлыг бодитоор хангах урт хугацааны үр нөлөөтэй алхмууд байх юм.

Зураг 5. Жендэрийн хувирган өөрчлөлтийг хийх ёстой талбарууд



Жендэрийн хувирган өөрчлөлт хийх боловсролын тогтолцоо нь ардчилсан, эрх тэгш, оролцоонд суурилсан нийгмийн үнэт зүйлийг төлөвшүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх хүчин зүйл болох юм. Тиймээс боловсролын үйлчилгээг үзүүлэхдээ бүхий л салбар буюу хүүхдийн өмнө үүрэг хүлээгч нартай хамтран ажиллахдаа сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийллээс ангид арга зүйг нэвтрүүлэх нь зүйтэй.



“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЛИЙН

ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, зэрэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх үр чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ОН.МН
СУДАЛГААНЫ САН